



U N
D P

Уул уурхайн салбарын авилгын эрсдэлийг бууруулах төсөл

УУРХАЙН ХААЛТЫН ЭРХ ЗҮЙ СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Хаалтын төлөвлөгөө хүлээн авах үйл ажиллагаа



Уул уурхайн салбарын авилгын эрсдэлийг бууруулах төсөл

**УУРХАЙН ХААЛТЫН ЭРХ ЗҮЙ БА ХААЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ ХҮЛЭЭН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Зөвлөх: Д.Жавхланболд

2016.12.20

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	5
ОРШИЛ.....	6
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО.....	7
СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ	9
УУРХАЙН ХААЛТ БА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	11
БАРУУН АВСТРАЛ:	27
БРИТИШ КОЛУМБ:.....	35
ФИЛИППИН:	37
ДҮГНЭЛТ	38
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	39

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
АҮ	Аж үйлдвэрийн
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БО	Байгаль орчин
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНБУ	Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОҮИТБС	Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлага
ОХУ	Оросын холбооны улс
ӨАБНУ	Өмнөд африкийн бүгд найрамдах улс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
УУ	Уул уурхай
УУГШУТ	Уул уурхай, геологи, шинжлэх ухааны товчоо
УУГТЯ	Уул уурхай, газрын тосны яам
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
ХОББЯ	Хүрээлэн буй орчин, байгалийн баялагийн яам
ADEQ	Arizona Division of Environmental Quality
DMP	Department of mining and petroleum
EPA	Environmental protection agency
ICMM	International council of mining and metals
MICC	Mining industry coordinating council
MMPO	Major mine permitting office
NIMBY	Not in my backyard
RSBC	Reclamation code for mines in British Columbia
SMART	Specific, Measurable, Achievable, Relevant, Time-bound

ОРШИЛ

2015 оны эцсийн байдлаар уул уурхайн салбар нь ДНБ-ний 16.1 хувийг, Төсвийн орлогын 20.7 хувийг, Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 67.2 хувийг, экспортын орлогын 78.8 хувийг дангаар бүрдүүлсэн байна. Харин 2016 оны 9 сарын байдлаар ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь (2016.IX) 30.5%, АҮ-ийн нийт үйлдвэрлэлд УУ-н үйлдвэрлэлийн эзлэх хувь (2016.IX) 71.7% байна. Эдийн засгийн бодит өсөлт 2016 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.1 хувьтай байгаа бөгөөд дээрх өсөлтөд уул уурхайн салбар 16.2 хувь, барилга 27.5 хувь, хөдөө аж ахуй 3.7 хувь, үйлчилгээний бусад үйл ажиллагаа 0.6 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.

Мөн 2015 оноос алтны нөөц ашигласны төлбөрийг бууруулсан, “Урт нэрт” хуулийн гацааг гаргаснаар алт олборлолтын хэмжээ нэмэгдэж үүнийг даган алтны ордын олборлолт, хөрөнгө оруулалт нэмэгдснээр уул уурхайн олборлолтод өртсөн газрын хэмжээ ч мөн ихээр нэмэгдэж байна.

2016 оны 10 дугаар сарын 10-н байдлаар хүчин төгөлдөр 3924 тусгай зөвшөөрөл, 14.7 сая га талбайг хамаарч байгаагаас, 1575 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 1.4 сая.га талбай, 2349 хайгуулын тусгай зөвшөөрөл 13.3 сая.га талбайд олгогдоод байна.

Ашиглалтын 1564 тусгай зөвшөөрөл байгаагаас барилгын материал, алт, жонш, нүүрсний тусгай зөвшөөрөл зонхилдог бөгөөд 259 тусгай зөвшөөрөл банк, санхүүгийн байгууллагын барьцаанд, барилгын материалаа гадна 300 орчим уурхай тогтмол үйл ажиллагаа явуулж байна. 400 гаруй ашиглалтын тусгай зөвшөөрөл хөрөнгө оруулалт шийдэгдээгүйн улмаас үйл ажиллагаа явуулалгүй зогсож байгаа бол 100 орчим шинэ тусгай зөвшөөрөл ТЭЗҮ боловсруулах шатандаа, нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 80 орчим хувь нь бага нөөц бүхий жижиг орд газарт олгогдсон байна.

Монгол Улсад сүүлийн 20-иод жилд уул уурхайн үйлдвэрлэлийн цар хүрээ эрчимтэй нэмэгдэж, олон орд газарт ашиглалт явуулсан ба голчлон “жижиг” уурхайнууд байж, газрын гадаргаас доош 50м орчим гүн малталтууд хийсэн. Бага гүнтэй уг малталтуудыг налуулах, дүүргэх боломжтой тул энэ чиглэлээр заавар журмууд гарч байсан байна. Уурхайн хаалт буюу ашиглалтын дараах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт өнгөрсөн хугацаанд түр журам төдийгөөр хэмжигдэж ирснээс нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Хамгийн сүүлд 2009-2010 онд БОАЖЯ-наас зохион байгуулсан эвдэрсэн газрын тооллогыг Хэнтий, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Өмнөговь, Дорноговь, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Говь-Сүмбэр, Дундговь, Сүхбаатар, Төв, Сэлэнгэ, Булган гэсэн нийт 15 аймагт хийсэн ба судалгааны дүнгээр уул уурхайн улмаас 15 аймгийн 56 сумын нутаг дэвсгэрт нийт 862 нэгж талбарт 2141,5 га газар эвдрэлд орж эзэнгүй орхигдсон байгааг судалгаагаар тогтоогоод байна. Дээрх хариуцлагагүй уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, хууль эрх зүйн зохицуулалт сул байгаа зэргээс үүдэн эзэнгүй гэж нэрлэгдэх болсон нөхөн сэргээгдээгүй талбай, хөрсний эвдрэл, гадаргын ус ширгэх зэрэг байгаль орчны бохирдолтой холбоотой олон тооны асуудал, ажилтан ажиллагсдын хөдөлмөр эрүүл ахуй, мал, амьтан ухсан нүхэнд унаж үхэх, бэртэх тухайн бүс нутгийн ард иргэдийн амьжиргаа, ахуйн асуудлууд уурхайн хаалттай холбоотойгоор шил шилээ даран гарч байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Монгол улс 1921 оны хувьсгалаас өмнө Монголор нийгэмлэгийн үед Хойд хэнтийн бүс нутагт хэд хэдэн алтны шороон ордыг ашиглаж байснаас гадна цаг хугацааг тодорхойлох боломжгүй төмөр, зэс зэрэг ашигт малтмалын орд газруудыг ашиглаж байсан ул мөрүүд Монгол Алтай, Говь, Хангайн бүсэнд нилээдгүй тохиолддог.

1922 онд Налайхын нүүрсний уурхайг ашигласнаар уул уурхайн салбарын үүсэл хөгжлийн тодорхойлж ирсэн бөгөөд 1989 онд уг Налайхын уурхай нь нөөц дуусаагүй байхдаа шатамхай хийн тэсрэлт болсноор ослын шалтгаанаар хаагдсан байдаг. Үүний улмаас Налайхын сууринд уг уурхайд ажиллаж байсан олон тооны хүмүүсийн нийгмийн асуудал шийдвэрлэгдэлгүй өнгөрч нүүрсний нинжа, бичил уурхайг бий болгосон ба хөдөлмөр хамгаалал, уурхайн дүрэм баримталдаггүйгээс осол аваарийн тоо буурахгүй хүний амь нас эрсдэх асуудал гарсаар байна.

Мөн Зөвлөлт холбоот улсын хөрөнгө оруулалттайгаар Бүрэнцогт, Түмэнцогт, Чоно гол, Мардайн хүдрийн ордуудыг олборлож байсан боловч ардчилсан хувьсгал гарч хоёр улсын хоорондын харилцаа өөрчлөгдсөнөөр уг ордуудын нөөцийг дуусгалгүй хааж уурхай дагасан жижиг суурингууд эзэнгүйдэж, тоногдон устсан гашуун түүх байдаг.

Уурхайн төлөвлөлтийг буруу хийсэнтэй холбогдон Шарын голын нүүрсний ордыг нөөц дуусгалгүй хаах нөхцөл бий болоод байгаа бөгөөд хэрэв энэ уурхай хаагдах тохиолдол Шарын гол суурингийн ард иргэдийн ажилгүйдэл, нийгэм ахуйн асуудал, уурхайг даган үүссэн бүтэц, цаашлаад суурингийн хэтийн асуудлыг шийдвэрлэхшаардлага урган гарч байна.

Жижиг хэмжээний дэд бүтэц бага шаардах, алт, цагаан тугалганы шороон орд, хайлуур жоншны жижиг ордууд олныг хаасан туршлага бидэнд байгаа бөгөөд зарим нь эрх зүйн зохицуулалт сулыг ашиглан нөхөн сэргээлт хийлгүй орхигдуулах, зугтах, эзэнгүйдүүлэх, нөөцийг сорчлон олборлож орд газрыг үнэгүйдүүлэх, тусгай зөвшөөрлөө өөр хүнд шилжүүлж зугтах зэрэг үзэгдлүүд нилээдгүй гарсан нь ард иргэдийг уул уурхайн салбарт итгэх итгэлийг хөсөрдүүлж, уул уурхайн эсрэг үзэл санаа бий болгох, цаашлаад байгаль орчны бохирдол доройтол үүсгэсэн байдаг. Энд гол усны бохирдол, газрын гадаргын эвдрэл, тоос шороо, бэлчээрийн доройтол зэрэг байгаль орчны холбогдолтой асуудлаас гадна гар аргаар алт олборлогчид олноор төвлөрснөөс газрын эвдрэл улам даамжрахаас авахуулаад нийгмийн хэв журам болон хүний эрхийн зөрчил зэрэг нийгмийн олон сөрөг үр дагавар хуримтлагдаж үлдсэн байна. Эдгээрийн цаана уг уурхайг тухайн үед ажиллуулж байсан хуулийн этгээд, тухайн үеийн хууль дүрэм журмын хүрээнд нөхөн сэргээлт хаалтыг хянаж хүлээн авсан төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн байгууллагын хооронд авилгалын асуудал үүссэн байж болзошгүй гэсэн хардлагыг бий болгодог бөгөөд эдгээр хардлагын зарим нь бодиттой байсныг ч үгүйсгэх аргагүй юм.

Үүнтэй холбоотойгоор ард иргэдийн зүгээс авилгал байна гэсэн хардлага байнга бий болдог нөгөө талаас тухай газар нутаг ахин ашиглах боломжгүй болж үлддэг гэж үздэг байна. Уурхайн хаалттай холбоотой авилгалын эрсдэлийн судалгааг IRIM-ийн зүгээс хийсэн бөгөөд эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага байгааг тогтоосон байна.

Эдгээр уул уурхайн компаниудын хэрэгжүүлсэн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хаалтын бодлого, төлөвлөгөө, зохицуулалт байхгүй байсны улмаас дараах үр дагавар гарч /Цэдэндорж нар, 2010/ байна:

а) *Байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл:*

- Эргэж сэргэх боломжгүй байгалийн үнэт баялгийг гүйцэд ашиглалгүй орхисноос тухайн үлдэж буй баялаг цаашид ашиглагдах боломжгүйгээр хаягдаж байна. Заамарт ажилласан зарим уурхайн баяжуулах төхөөрөмж металлын 90-ээс дээш хувийг авахаар төлөвлөж байсан ч бодит байдал дээр 50 орчим хувийг авч байсан тухай яригддаг.
- Газрын гадарга, хэвлийд нүх, ухаш, овоолго үүсгэснээс болж гадаргын төрх байдал дордо. Туул гол дагуух хайрганы орхигдсон уурхайнууд үүний жишээ болно.
- Агаар, хөрс, гадаргын болон гүний ус бохирдож экологийн доройтол үүслээ. Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт энэ жишээ маш тод харагдаж байна.
- Ургамлын төрөл зүйл өөрчлөгдөх, амьтад дайжих, устаж үгүй болох үр дагавар үүсэж байна. Харамсалтай нь суурь судалгаа, явцын мониторингийн мэдээлэл байхгүй учраас энэ талаар иш татах бэлэн жишээ байхгүй байна.
- Уул уурхайн ашиглалт дууссаны дараагаар уг үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл нь их бага хэмжээгээр олон жилийн турш үргэлжилж байдаг ч энэ талаар ямар нэг үнэлгээ, мониторинг хийгдэхгүй байна.

б) *Бүс нутгийн болон орон нутгийн нийгэм эдийн засагт тусгах нөлөө:*


- Уул уурхайн төсөл хэрэгжих явцад тухайн орон нутгийн эдийн засаг уг төслөөс тодорхой хэмжээгээр хараат болж байна.
- Нутгийн оршин суугчдын амьдралын хэвшил, ажил эрхлэлтийн бүтэц өөрчлөгдөж байна. Хөдөлмөрийн насны нийт хүн амын 30 түүнээс ч илүү хувь нь уурхайд ажиллах, уурхайд ажил үйлчилгээ нийлүүлэх зэргээр орон нутгийнхаа нэг уурхайтай холбоотой ямар нэг бизнесийг эрхэлдэг сумууд бий болж эхэллээ. Цаашдаа иймэрхүү бүтэцтэй аймаг ч бий болж магадгүй байна.
- Уул уурхайн компани дампуурах тохиолдолд орон нутгийн хувьд төлөвлөгдөөгүй олон сөрөг асуудлууд хуримтлагдаж үлддэг.
- Төсөл хэрэгжиж дууссаны дараагаар уул уурхайд ажиллаж байсан хүмүүсийн ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхгүй орхивол ядуурал, ажилгүйдэл нэмэгдэнэ. Налайхын уурхай гэнэт хаагдсаны дараа нийтийг хамарсан ажилгүйдэл үүссэн, улмаар иргэд амь насаа алдах эрсдэл бүхий гар аргаар нүүрс олборлох үйл ажиллагаа эрхлэх болсон зэрэг нийгэм, эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл өнөөдөр ч үргэлжилсээр байна.
- Төслийг дэмжиж байгуулагдсан дэд бүтцийг цаашид орон нутаг ашиглахад арчилгаа, зардлыг нь дийлэхгүй орон нутагт дарамт үүсэх асуудал гарч байгааг Өргөний уурхайн тосгоны жишээ харуулж байна.

Эндээс уурхайн хаалт нь эрх зүйн нарийн зохицуулалт, төслийг хэрэгжүүлэгч, хянагч болон бусад бүх оролцогч талаас ихээхэн хүчин чармайлт шаардсан, анхнаас нь төлөвлөж, төсөвлөж байх шаардлагатайг харуулж байна.

Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны зүгээс уул уурхайн тухай хууль боловсруулах түүн дотроо уурхайн хаалтын тухай эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд төслийн зүгээс тус ажлын хэсэгт шаардлагатай нэмэлт нарийвчилсан судалгааг ажлын хэсгийн зүгээс хаалтын төлөвлөгөөг өгөх, батлах талаар нарийвчилсан харилцааг зохицуулах судалгаа хийж санал боловсруулахыг хүссэний дагуу энэхүү судалгааг хийж байна.


СУДАЛГААНЫ АРГА, АРГАЧЛАЛ

Энэхүү судалгааг хийхдээ дэлхий улс орнуудын уул уурхай, байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журмуудтай танилцаж, уурхайн хаалтын үе шатанд мөрдөж буй эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан түүвэрлэж судаллаа.



Хууль зүйн шинжлэх ухаанд ерөнхийдөө норматив буюу прескриптив, экспликатив буюу дескриптив, харьцуулалтын гэсэн арга зүйг түгээмэл хэрэглэдэг бөгөөд норматив арга зүй нь байх ёстой зүйл, хэм хэмжээг чухалчилж метафизик, түүхчлэх болон логик зарчмуудыг баримталдаг бол нөхцөл байдлыг шинжлэх дескриптив арга зүй нь тухайн цаг үеийн бодит байдлыг судалсны үндсэн дээр үнэлэлт дүгнэлт өгдөг байна. Харьцуулсан арга зүйн нь танин мэдэхүй болон дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэсэн ололт дээр тулгуурлаж байдаг.

Ерөнхийдөө судалгааг онолын, системчилсэн, харьцуулсан судалгаа гэж ангилдаг бөгөөд энэхүү судалгаанд системчилсэн хэлбэрээр харьцуулсан судалгаа хийж үр дүнг нь нягтлан шинжилж (анализ) оновчтой хувилбарыг түүвэрлэх замаар Монгол улсын эрх зүйн орчин, төрийн байгууллагын бүтэц зохион байгуулалтад тохирох хувибарыг боловсруулах замаар хийж гүйцэтгэлээ.



Судалгааг хийхдээ эрх зүйн тогтолцоо, улс төр, засаглалын тогтолцооны хэв маягаас шалтгаалан ялгамжтай эрх зүйн зохицуулалттай байгааг харгалзан ангилж үзэх төлөвлөгөөг боловсруулахдаа ашигт малтмалын төрөл, уурхайн хэлбэр/ил, далд/, баяжуулах үйлдвэр, хорт бодис, уурхайн хэмжээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл зэргээс

шалтгаалан агуулгыг хувьд ялгаатай байх, санхүүгийн баталгаа буюу барьцаа байршуулахад өөр өөр арга механизм ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, нөгөөтэйгүүр энэ тухай хаалтын төлөвлөгөөг хүлээн авах, хянах, батлахад оролцогч талуудын хувь оролцоог зохицуулах нөхцөл болох талаас судалж дүгнэлт хийлээ.

Эрх зүйн зохицуулалтыг ангилх төрөлжүүлэхэд эрх зүйн онолын болоод уул уурхайн мэргэжлийн талаас харж үнэлж цэгнэх нь илүү зохимжтой байсан бөгөөд дан ганц эрх зүйн зохицуулалтаар ангилах өрөөсгөл шинжтэй болох юм. Мөн улс орон бүрийн төрийн байгуулалт, улс төрийн тогтолцооноос шалтгаалан оролцогч талуудын эрх, хэр хэмжээ, оролцоо ялгамжтайгаар авч үзэх шаардлагатай болж байв.


Судалгааны явцад улс орнуудын уурхайн хаалтын төлөвлөгөө, түүнийг хүлээн авах процесс нь тухайн орны эрхзүйн тогтолцоо, төрийн байгуулалтаас ихээхэн хамаарч байна. Ерөнхийдөө дэлхийн улс орнуудын эрхзүйн тогтолцоог Civil law, Common law, Customary law, Muslim law and Mixed law systems гэж ангилсан байдгаас гадна хууль бичих техник талаасаа роман болон англо-заксоны гэж ангилдаг. Мөн Монголын хуульчдын дунд эрх зүйг эх газрын буюу роман, далайн буюу англо-заксоны эрх зүй гэж ангилах нь бий. Эрх зүйн энэ тогтолцооны ангилалаас шалтгаалан газар түүнийг өмчлөл өөр өөр байдаг ба газрын хэвлийн баялаг түүнийг ашиглах, захиран зарцуулах, буцааж хүлээлгэн өгөх талаарх зохицуулалт ялгаатай байна.

Монгол улсад томоохон уурхай хаасан туршлага одоогоор байхгүй бөгөөд Зөвлөлтийн үеийн бүрэнцогт, түмэнцогт, бэрх, хажуу улааны уурхайг хаахдаа нөөцийг бүрэн ашиглалгүй орхигдуулсан улстөрийн дэглэм өөрчлөгдөж зөвлөлтийн мэргэжилтэн, хөрөнгө оруулалт гарч явснаар зогссон. Мөн бүрэн хааж тухай газрыг өөр зориулалтаар ашиглах боломжийг нээгээгүй үлдэгдэл нөөцийг яаж олборлох, сорчлон ашигласнаас үүдэн ядуу агуулгатай хэсэг үлдсэн зэрэг хүндрэл байгаа болно. Алт, жонш, кассетерит, вольфрамын жижиг шороон ордууд болон барилгын материалын уурхай хаасан туршлага байх боловч газрыг хэлбэршүүлэн ухсан нүхийг дарсанаас бодит төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй байна. Иймд саналыг боловсруулахдаа гадаад орнуудын туршлагыг голчлон анхаарч Монгол улсад тохиромжтой хувилбарыг дотоодын төрийн байгууллагын тогтолцоо, бүтэц, эрхзүйн зохицуулалтыг харгалзан боловсруулсан болно.

УУРХАЙН ХААЛТ БА ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэхүү судалгаанд дэлхийн 200 гаруй орнуудаас уул уурхай хөгжсөн орнуудыг ялган авч тэдгээрийг эрх зүй, төрийн тогтолцооны талаас нь нарийвчлан ангилж үзхээр түүвэрлэлт хийлээ. Дэлхийн банкнаас хөгжиж буй орнуудын дунд хийсэн судалгаагаар уул уурхай хөгжсөн улс орнуудад тухайн улсын экспортод эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээг гол үзүүлэлт болгон хэрэглэсэн бөгөөд 50 хувиас дээш хувьтай улс орнуудыг уул уурхай зонхилсон (mining dominant), 15-50% улс орнуудыг уул уурхай чухал ач холбогдолтой гэж ангилсан байна. ICMM(International council of mining and metal) 2012 онд хийсэн судалгаандаа уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хувь хэмжээгээр нь уул уурхайн тэргүүлэх 20 улс орноор 1.Australia, 2.China, 3.Brazil, 4.Chile, 5.Russian Federation, 6.South Africa, 7.India, 8.United States, 9.Peru, 10.Canada, 11.Indonesia, 12.Ukraine, 13.Mexico, 14.Kazakhstan, 15.Iran, Islamic rep., 16.Philippines, 17.Sweden, 18.Ghana, 19.Zambia, 20.Papua New Guinea нэрлэсэн байна. Харин экспортод эзлэх уул уурхайн бүтээгдэхүүний хувь хэмжээгээрээ 1.Botswana 2.Zambia. 3.Dem. Rep. of the Congo 4.Mongolia 5.Suriname 6.French Polynesia 7.Chile 8.Guinea 9.Peru 10.Mauritania 11.Northern Mariana Islands 12.Mozambique 13.Mali 14.Sierra Leone 15.Papua New Guinea 16.Namibia 17.Nauru 18.Armenia 19.Jamaica 20.Cuba гэсэн улсуудыг уул уурхайгаас хамааралтай экспортлогч 20 улсаар ангилсан байна.

Улс орнуудын эдийн засгийг уул уурхайгаас хамаарах байдлаар нь зураг-1-д авч үзвэл:



Зураг 1.Улс орнуудын эдийн засаг уул уурхайгаас хамаарах байдлаар ангилсан зураг. Эх үүсвэр ICMM судалгаа.

Энэхүү судалгаанд манай улстай ижил түвшний эдийн засгийн хөгжилтэй улс орнууд болон, уул уурхайн тэргүүлэгч ба уул уурхайгаас хамааралтай улс орнуудыг судалгаандаа хамааруулахаар зорьлоо.

Монгол улс нь үндсэн хуулинд заасны дагуу төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс бөгөөд 6 дугаар зүйлд газар, түүний хэвлий нь ард түмний мэдэлд төрийн хамгаалалтад буюу төрийн өмч байхаар зааж, хуульд заасан болзол, журмаар ашиглуулж болох ба төр буцааж хүлээн авахаар журамласан байна.

Зургадугаар зүйл.

1. Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.

2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.

3. Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно. Энэ нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй. Иргэд хувийн өмчийнхөө газрыг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах зэргээр гадаадын иргэн, харьяалалгүй хүний өмчлөлд шилжүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад эзэмшүүлэх, ашиглуулахыг хориглоно.

4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

5. Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно.

Дэлхийн улс орнуудын хувьд нэгдмэл улс болон холбооны улс гэсэн 2 үндсэн төрөлд хуваагдах ба холбооны улс нь эрх зүйн олон давхрагатай, хууль тогтоомжоо холбооны болон муж улсын гэж ангилдаг. Ийм улс орнуудын тоонд АНУ, ХБНГУ, Канад, Австрал, ОХУ зэрэг улсууд ордог боловч эдгээрээс ОХУ нь холбооны улс боловч эрх зүйн хувьд харьцангуй нэгдмэл улсын тогтолцоотой юм.

Мөн эрх зүйн хувьд нэгдмэл улс боловч дотроо ерөнхийлөгчийн засаглалтай, парламентийн засаглалтай гэж ангилагдах ба Индонез, Казахстан, Чили, Перу зэрэг нь ерөнхийлөгчийн засаглалтай, Киргизстан, ӨАБНУ, Монгол улс нь парламентийн засаглалтай улс юм. Мөн пост коммунист улс орнуудын хувьд төрийн байгуулалт, эрх зүйн хувьд төстэй шинж байдал ажиглагддаг бөгөөд Газрын хэвлийн хуулиар ашигт малтмал эрэх хайх, олборлох, борлуулах харилцааг зохицуулдаг.

Уул уурхайн хаалтын төлөвлөгөөг өгөх, хүлээн авах, хянах, батлахдаа улс орнууд тусдаа ялгаатай хууль эрхзүйн зохицуулалтай, үе шаттайгаар хэрэгжүүлдэг бөгөөд тухайн улс орнуудын төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, орон нутаг, иргэн, төрийн бус байгууллагын хуулиар тогтоосон эрх, хэр хэмжээ, үүрэг, зохицуулалтаас шалтгаалж байхад нөгөө талаар эрх төлөвлөгөөний агуулга, бүтэц, уурхай, баяжуулах үйлдвэрийн төрөл, ашигт малтмалын төрөл, хэмжээ, эдийн засаг нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөл, зэргээс хамааран ялгаатай нөхцөлтэй журамлагдсан байдаг байна.


Тухайн ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах шатнаас эхлэн уурхайн хаалтын асуудлыг төлөвлөх, шийдвэрлэх нь зүйтэй гэсэн нэгдсэн ойлголт дэлхийн уул уурхайн практикт тогтож хэвшиж байна. 2008 оноос эхэлсэн дэлхий дахиныг хамарсан эдийн засгийн хямралын улмаас гэнэт үйл ажиллагаагаа зогсоосон олон уурхайг зогсоох улмаар хаах асуудал гарч ирсэн нь уурхайн хаалтыг төлөвлөж байснаас эрт хийх шаардлага нөхцөлийг бий болгож ихээхэн эрсдэлтэй гэдгийг харуулсан юм.

Төлөвлөгдөөгүй уурхайн хаалтын асуудал нь дэлхийн уул уурхайн салбарын судлаач эдэмтдийн дунд шинэ арга аргачлал зохицуулалт хийхийг шаардаж байгаа бөгөөд Мак.Кензие нар уг асуудлаар судалж санал боловсруулан авах арга хэмжээний стратеги, бодлогыг тодорхойлохыг оролдсон байдаг.

Төлөвлөгдөөгүй уурхайн хаалт нь түүхий эдийн үнийн уналт, үйл ажиллагааны зардлын өсөлт, геотехникийн нөхцөл, тоног төхөөрөмж, хөдөлмөр хамагаалал, байгаль орчны бохирдол, доройтол, иргэний нийгмийн шахалт, засгийн газрын бодлогын өөрчлөлт, ашигт малтмалын агуулга, нөөцийн буруу тооцоо, байгалийн гамшиг зэргээс шалтгаалдаг гэж үзсэн бөгөөд дараах таван алхамыг хэрэгжүүлхийг зөвлөсөн байдаг.

- 1-р алхам: Одоогийн нөхцөл байдлын үнэлж анхны төлөвлөлтөөс үүсэх зөрүү тооцох
- 2-р алхам: Үүссэн мэдээллийн зөрүүг нарийвчлан судалж шийдэл хайх
- 3-р алхам: Уурхайн халтын төлөвлөгөө шинэчлэн боловсруулж батлах
- 4-р алхам: Уурхайг хаах, чөлөөлөх
- 5-р алхам: Хаалтын дараахь мониторинг, тайлагнах, бонд дүгнэх

Харин Лауренс өөрийн судалгаанд уурхайн хаагдах шалтгааныг нилээд нарийвчлан судалж статистик тоо баримтуудад илүү тулгуурласан дүгнэлт хийсэн байна.



Зураг 2. Уурхай хаагдахад нөлөөлсөн шалтгаанууд (Д. Лауренс)/Цэдэндорж нар 2010/

Өнгөрсөн түүх ба одоогийн туршлагаас харахад уурхайг цогцоор хаах нь хамгийн сайн арга гэдэг харагдаж байгаа боловч уул уурхай хөгжсөн улс орон бүрт ижил бусаар зохицуулалт, хийж нөхцөл байдлыг авч үзсэн байх бөгөөд уул уурхайн компаниуд ч энэ талаар нэгдсэн нэг ойлголттой бус байгаа нь ажиглагддаг. Тийм ч учраас уул уурхайн хуулиндаа хаалтын талаар зохицуулалтыг шууд тусган хэрэгжүүлж байгаа нэг хэсэг улс орнууд байхад хүрээлэн буй орчны үнэлгээний хууль болон бусад хууль эрх зүйгээр зохицуулалт хийж байгаа улс орнууд ч байна. Мөн тун цөөхөн улс зарим муж улсууд

жишээлбэл Чили, ӨАБНУ, Онтарио муж, Невада муж нь хаалтын талаар биеээ даасан хууль гарган хэрэгжүүлэх алхамуудыг ч хийж байна.

Хэрэгжүүлэх арга замын хувьд гол төлөв техник эдийн засгийн үндэслэл, уурхайн хаалтын төлөвлөгөө эсхүл байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны хамгаалах төлөвлөгөө гэсэн хувилбараар төлөвлөлт хийж Засгийн газар хяналт тавих нь элбэг байдаг ба төлөвлөгөө хэрэгжихэд санхүүгийн нөөц, бонд, баталгаа зэргийг бодитоор тусгаж хэрэгжүүлдэг улс орнууд ч байдаг байна.

Уурхайн хаалтыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтаар нь ерөнхийдөө хоёроос гурван ангид бүлэглэж үзэх боломжтой байна.

А бүлэг:

Улс, муж улс	Нөхөн сэргээлтийн тусгайлсан заалт	Тусгай зөвшөөрөл, түрээсээс өмнө БОНБУ шаарддаг эсэх	Бондын процедур	Орхигдсон уурхайг зохицуулах заалттай эсэх	Дагаж мөрдөөгүй тохиолдол хариуцлага тооцох эсэх
Австрал					
- Шинэ өмнөд Уэльс	+	+	+	-	+
- Хойд газар нутаг	+	+	+	-	+
- Квинсланд	+	+	+	+	+
- Өмнөд австрал	+	+	+	+	+
- Виктория	+	+	+	+	+
- Баруун австрал	+	+	+	+	+
Канад					
- Бритиш колумбия	+	+	+	+	+
- Манитоба	+	-	+	-	+
- Шинэ Брунсвик	+	+	+	-	+
- Баруун хойд нутаг	+	+	+	-	+
- Нова скотия	+	+	+	+	+
- Онтарио	+	+	+	+	+
- Квюбек	+	+	-	-	-
- Саскатчеван	+	+	-	-	-
- Юкон	+	+	+	-	+
Герман	+	+	+	-	+
Ирланд	+	+	+	+	+
Их британи	+	+	+	+	+
АНУ					
- Аляск	+	+	+	-	+
- Аризона	+	+	-	-	+
- Калифорн	+	+	-	+	+
- Невада	+	+	+	-	-
- Монтана	+	+	-	+	+
- Юта	+	+	-	+	+
- Нью Мексик	+	+	-	-	+
- Вашингтон	+	+	-	-	+

Япон	+	+	+	+	+
Чили	+	+	+	-	+
ӨАБНУ	+	+	-	-	+

Б бүлэг:

Улс, муж улс	Хаалтын хэлэлцээ	БОНБУ шаарддаг эсэх	Нийгмийн нөлөөллийн үнэлгээ шаарддаг эсэх	Нөхөн сэргээлтийн шаардлага	Бонд шаарддаг эсэх
Буркино фасо	-	+	+	+	+
Ботсван	+	+	-	+	-
Заану ясан эрэг	-	+	-	+	+
Гана	-	+	-	+	-
Намиби	-	+	-	+	-
Танзани	+	+	-	+	-
Замби	-	+	-	+	+
БНХАУ	+	+	+	+	+
Индонез	+	+	-	+	+
Энэтхэг	+	-	-	+	-
Казахстан	-	+	-	+	+
Киргизстан	+	+	-	+	-
Лаос	-	+	+	+	+
Малайз	+	+	-	+	-
Монгол	-	+	+/-	+	-
Филиппин	-	+	+	+	+
Узбекистан	+	-	-	+	-
Эквадор	-	+	-	-	-
Мексик	+	+	-	+	-
Перу	-	+	+	+	-
Венесуел	+	+	-	-	-
Иран	+	+	-	+	-
Папуа шинэ гвиней	+	+	-	-	-

Ерөнхий байдлаар авч үзвэл уурхайн хаалтаар уурхай ашиглаж байгаад хааж орхисон газарт аюулгүй орчин бүрдүүлсэн байх, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, нэгэнт бий болсон дэд бүтэц, барилга байгууламжийг цаашид аль болох үр ашигтай ашиглах, уурхай хааснаас үүдэн гарах нийгэм эдийн засгийн сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулсан байх, хаасан уурхайн орчим ба түүний объектуудад урт хугацаанд мониторинг хийх, хяналт тавих зэрэг асуудлыг шийдэх ёстой /Цэдэндорж нар, 2010/ бөгөөд судалгаанд суурьласан хэрэгжихүйц бодит, асуудлыг олон талаас нь харж үзсэн, эрсдэлээ тооцсон төлөвлөлт байх ёстой юм.

А бүлэгт хамаарч байгаа улс орнууд нь гол төлөв холбооны эрх зүйтэй уул уурхай олон жил хөгжсөн туршлагатай бөгөөд уурхайн хаалтын талаар эрх зүйг харьцангуй цогц байдлаар боловсруулан баталж мөрдөж, бие даасан хаалтын хуулиас гадна уул уурхайн хуулиндаа хаалтын талаар зохицуулалтыг тусгаж Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ, Байгаль орчны хуулиудаар хамтад нь олон тооны стандарт шаардлага, журмаар

зохицуулсан байдаг. Мөн ихэнхи бонд болон санхүүгийн бусад арга хэрэгслээр баталгаа гаргахаар заасан нь төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах үр дүнтэй шийдэл болж байна.

Энэ бүлэгт байгаа бүх шууд болон шууд бусаар уурхайн хаалттай холбоотой олон тооны эрх зүйн баримт бичгүүдийг батлан мөрдүүлж байгаа бөгөөд АНУ гэхэд Холбоону улсын хэмжээнд Үндэсний байгаль орчны бодлогын акт /National environmental policy act 1969/, цэвэр агаар хууль /Clean air act 1970/, Цэвэр усны хууль /the clean water act 1972/, Баялгийн консерваци ба нөхөн сэргээлтийн хууль /the resource conservation and Recovery Act 1976/ -муж улс бүр журам, зааварчилгаа, техникийн шаардлага, стандартыг батлан уурхайн хаалтыг зохицуулж байна. Харин Их британий хувьд Байгаль орчны яамнаас гаргасан Ашигт малтмалын бодлогын удирдамжын 7 дугаар тэмдэглэл буюу “Ашигт малтмалын үйл ажиллагааны нөхөн сэргээлт” гэсэн журмын хүрээнд орон нутгийн агентлагууд хариуцан хэрэгжүүлдэг байна.

Ер нь гол нь байгаль орчны нөхөн сэргээлтэнд л өндөр ач холбогдол өгдөг бөгөөд үүнийгээ greenfield концепц гэж ерөнхийдөө нэрлэдэг. Бас good corporate citizen гэдэг ойлголт байх ба иргэдтэй хамтран ажиллах хариуцлагатай уул уурхайн зарчмыг хэрэгжүүлэх, нийгмийн зөвшөөрөл өгөх гэдэгтэй ижил ойлголт болно. Орон нутгийнхантай харилцах хүрээнд NIMBY /буюу not in my backyard гэдэг хэлцийн товчлол/ зарчим хүчтэй хөгжиж байгаа бөгөөд энэ нь 1950-60 оны үйлдвэржилтийн үед үүссэн байна. NIMBY гэдэг нь хөгжлийн шинэ санал(хөгжлийн төсөл, үйлдвэр нь технологийн хувьд аюултай, маргаантай гэж үзэх)-д оршин суугчдын зүгээс үзүүлж буй үл итгэж, үл тоосон шинж чанар бөгөөд цаад утгаараа эдийн засаг, нийгэмд шаардлагатай боловч миний амьдардаг газраас хол байх ёстой гэсэн утга юм. Энэ үзэл сүүлийн үед улам бүр хөгжиж not in my neighborhood, not against my business or industry, not in anyone's backyard гэх мэт утга санаагаар баяжигдаж байна.

Greenfield концепц нь нөхөн сэргээлт, ургамалжуулах чиглэлээр хөгжиж байгаа үзэл бөгөөд үүнтэй холбогдуулан улс орнууд өөрийн түвшинд стандарт шаардлагуудыг хөгжүүлж, баяжуулан, шинэчилж ирсэн.

Мөн бохир урсац, хүчлийн урсац зэрэгтэй холбогдуулан түүнийг арилгах, урт хугацааны мониторинг, үйлчилгээ хийх талаар заавал тусгасан байх нь NIMBY, Downstream business зэрэг зарчмуудаар хянагдаж байдаг гол үзүүлэлтийн нэг болдог.

Агаарын бохирдол, усны бохирдол зэрэг байгаль орчны холбогдолтой асуудал нь хамгийн их хүлээлт үүсгэдэг онцгойлон анхаардаг байсан ол сүүлийн үед үүнээс гадна уугуул иргэд, тэдний ахуй, амьдралын хэв маягт нөлөөлөх нөлөөлөл зэрэг нийгмийн чанартай суудлыг ихээхэн анхаарах болсон байна. Бритиш колумбт гэхэд уугуул иргэд, ойн аж ахуйн асуудлаар хийсэн хэлцэл 10 орчим жил үргэлжилсний эцэст шийдвэрлэгдсэн байдаг байна.

Уурхай үйл ажиллагаа бүрэн зогсож нөөц шавхагдсан үед төрийн байгууллагууд баталгаажуулахаас өмнө, олон улсад нэр хүндтэй геотехник, байгаль орчины зөвлөх үйлчилгээний компаниудаар үнэлгээ хийсэн байх ёстой бөгөөд үүний үр дүнд уг төлөвлөгөө бүрэн хэрэгжих эсэх, эсхүл нэмэлт өөрчлөлт хийж нөхөн сэргээлт, хаалт, мониторингийн шийдэлийг зөв болгохыг шаарддаг.

Баруун австрал муж улс 2011 онд Уурхайн хаалтын төлөвлөгөө болосвруулах зааврыг баталж 2015 онд уг заавартаа нэмэлт өөрчлөлт оруулж шаардлагыг нэмэгдүүлсэн

ба энд төлөвлөгөөний агуулга хайгуулын үе шатнаас уурхайн хаалтын дараах мониторинг, үйлчилгээ үе хүртэл өргөн хүрээнд авч үзэх, төлөвлөгөө хянах хуудас/checklist/-д хянаж буй хүний санал бичих багана нэмсэн.

Төлөвлөгөөг хүлээн авахдаа төслийн хэрэгжих хугацаанаас хамаарч 10 хүртэлх жил бол төсөл эхлэхээс өмнө хаалтын төлөвлөгөө нарийвчилсан байдлаар хийж, хаалтын дараах гадаргын хэлбэр, нөхөн сэргээлт, дэд бүтэц, үйлдвэрийн барилга байгууламжийг чөлөөлөх, хүлээлгэн өгөх хэлбэр, хаалтын дараах мониторинг, үйлчилгээ /maintenance/-ний талаар заавал нарийвчилсан мэдээлэл, судалгааг хийсэн байхыг шаарддаг бол урт хугацаанд хэрэгжих /10-аас дээш/ төслийн хувьд төсөл эхлэхээс өмнө хаалтын ерөнхий төлөвлөгөөг хийж батлуулан төслийн явцад нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулдаг.

Бритиш Колумбын хувьд уул уурхайн хууль /[Mines Act](#) RSBC 1996/, Бритиш колумб дахь уурхайн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал ба нөхөн сэргээлтийн код /[Health, Safety and Reclamation Code for Mines in British Columbia](#)/ -оор зохицуулдаг бөгөөд сүүлийн үед томоохон уурхайн зөвшөөрлийн алба / [Major Mine Permitting Office \(MMPO\)](#)/ байгуулагдснаар зохион байгуулалт, зохицуулалт илүү боловсронгуй болж байна.

Чили улс нь 1994 оны хүрээлэн буй орчны тухай хуулийн хүрээнд уурхайн хаалтыг зохицуулж байсан бөгөөд 2012 онд уул уурхайн хаалтын хууль /Law 20,551 Regulating Mines and Installations Closure/ баталснаар уул уурхайн хаалтын эрх зүйн сайн зохицуулалттай улсын тоонд хамаарах болсон. Уг хууль батлагдсанаар хуулийн дагуу хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологи, уул уурхайн агентлаг байгуулагдаж Уул уурхайн хаалтын төлөвлөгөө хүлээн авах аргачилсан заавар /Methodological Guides for the Submission of Mine Closure Plans/, хаалтын минимум шаардлага, стандартыг боловсруулан мөрдөж байна.

Б бүлэгт багтах улс орнууд нь гол төлөв нэгдсэн улсын төрийн байгуулалттай гол төлөв ашигт малтмал, уул уурхайн хуулинд хаалтын талаар зохицуулалттай харьцангуйгаар уул уурхайн салбар сүүлд хөгжсөн улс орнууд орж байна. Гэвч сүүлийн жилүүдэд Өмнөд Америкийн Аргентин, Боливи, Колумби, Эквадор, Бразил, Чили, Перу улсуудад уурхай эрхэлж байсан газар нутгийг нөхөн сэргээх асуудлаар эрх зүйн зохицуулалт батлан мөрдүүлж байна. **Чилийн** уул уурхайн хуулиудад уурхайн хаалтад тавих шаардлагууд, мөн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулах талаар ерөнхий удирдамж багтсан байна. 2012 онд "Уурхайн хаалтын тухай хууль Law № 20.551 "-ийг баталж уурхайг хаах техникийн төсөл, олон нийтэд нээлттэй зарлах мэдээлэл, санхүүгийн баталгаа зэрэг асуудлыг тусгасан байна. Перугийн хуулиар уул уурхайн компани нь газрыг нөхөн сэргээх арга хэлбэр, хаалтын үйл ажиллагааны төсвийн төсөөлөл, хяналт болон баталгаажуулах үйл явц, хаалтын болон хаалтын дараах үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн баталгаа зэргийг нарийвчлан заасан төлөвлөгөө гаргаж өгөх шаардлага тавьдаг бөгөөд хэрэгжилт нь хэвшсэн байна.

Мөн Б бүлэгт багтсан улс орнууд шинэхэн ашигт малтмалын тухай хуультай сайжруулах чиглэлээр олон дахин нэмэлт өөрчлөлт хийж тодорхой хэмжээгээр ахиц гаргаж байга юм. Чили улс гэхэд 2012 он хүртэл Б бүлэгт хамаарч байсан бол байгаль орчны яамны санаачлагаар уурхайн хаалтын эрх зүйгээ боловсронгуй болгох дорвитой алхам хийж чадсан юм.

Индонез улс 1967 оны уул уурхайн хуулий 2009 онд эрдэс баялаг ба нүүрсний уурхайн хууль / Law on Mineral and Coal Mining No. 4/ -ийг шинэчлэн баталсан нь эрх зүйн хувьд томоохон өөрчлөлт хийсэн бөгөөд гадаадын хөрөнгө оруулалт, гэрээний эрх зүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн байна. Уурхайн хаалттай холбогдуулан 2010 онд журам баталсан ба 2 шатанд зохицуулалт хийсэн бөгөөд муж, бүсийг дамнасан уурхай, гадаадын хөрөнгө оруулалттай, чухал буюу стратегийн ашигт малтмалын орд, төрийн өмчит компаний хаалтын асуудал нь төв засгийн газар хамаарах бол дотоодын хөрөнгө оруулалттай нэгж мужид багтах уурхай нь орон нутгийн түвшинд хаалт хийгдэхээр зохицуулсан байдаг. Хаалтын төлөвлөгөөг эрчим хүч эрдэм баялгийн яаманд хүлээлгэн өгөх ба уурхайн хяналт хийх эрх бүхий засгийн болон орон нутгийн агентлаг, байгууллагууд бүс нутгийн хөгжлийн агентлаг, Байгаль орчны хамгаалах товчоо, нийгмийн асуудлын яам, Ойн яам, хөдөө аж ахуйн салбараар хянуулж, саналыг авахаас гадна уул уурхайн үйл ажиллагаатай шууд хамаарал бүхий иргэд, нийгмийн байгууллагаас санал авсны үндсэн дээр баталдаг.

Хаалтын санхүүгийн баталгаа бий болгосон давуу талтай бөгөөд санхүүгийн баталгааг төлөвлөгөөнд тусгагдсан төсөв, шууд ба шууд бус зардалыг тооцон баталгааны хэмжээг тогтоодог. Хаалтын дараа хяналтыг тогтмол хийх бөгөөд жил бүрийн хаалтын ажлын тайлан, мониторинг тайланг ирүүлэх ба хэрэв хаалтын ажлыг төлөвлөгөөнд тусгасаан өөрөөр эсхүл гүйцэтгэл 60%-иас бага бол гуравдагч этгээдээр хаалтын ажлыг хийлгэх зэргээр журамласан байна. Хаалтын төлөвлөгөөг 5 жил тутамд шинэчлэхээр заасан ба эцсийн төлөвлөө буюу post-mining төлөвлөгөө гэж ангилсан байдаг.

Хаалтын төлөвлөгөө дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байдаг. Үүнд:

- Орд газрын тухай мэдээлэл (газрын гадарга, лицензийн хил, байгууламжууд г.м);
- Хаалт хийх процедурыг заасан тодорхойлолт, мөн хаалтын өөр бусад хувилбаруудад өгсөн судалгаа дүгнэлт;
- Тухайн газрын болон бүс нутгийн ус зүй, геологийн тогтоц;
- Барилга, байгууламж тус бүрийг хаах нарийвчилсан арга ажиллагаа;
- Хаалтын дараа үргэлжлүүлэн нөлөөлөл өгөх байгууламжуудаас гүний усанд үзүүлэх нөлөөлөл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй болохыг нотолсон загварчлал тооцоо;
- Компани хаалтыг зохих ёсоор хийж чадахыг баталсан санхүүгийн баталгаа;
- Компани болон түүний туслан гүйцэтгэгч нь хаалтыг иж бүрэн хийх техникийн чадамжтайг харуулах зэрэг болно.

Хаалтын дараах нөхцөл байдал, урт хугацааны хяналт мониторингийн төлөвлөгөөнд үндэслэн хаалтын зөвшөөрлийг олгодог. Үүнд:

- Цаашид үлдэж хоцрох байгууламжуудад хаалт хийгдсэн байдал (уусгалт хийгдсэн овоолго, хаягдлын далан г.м);
- Хаалтын дараах хөрсний нөхцөл байдлын үнэлгээ;
- Хаалт хийгдсэн байгууламжуудад хийгдэх үзлэг, шалгалт, гүний усны чанарын хяналт, мониторингийн төлөвлөгөө;
- Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан бохирдол гарах, гүний усны чанар муудах, хаалт хийгдсэн байгууламжууд эвдрэх зэрэг тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө;

- Бүртгэл, тайлагналын төлөвлөлт;
- Гүний усны моделийг ирээдүйд шинэчилж байх асуудал зэрэг багтана.

Олон улсын түвшинд уурхайн хаалтын зохицуулалт, хяналтын асуудлыг эрхлэн ажилладаг байгууллага байхгүй ч дэлхийн болон олон улсын санхүүгийн байгууллагууд энэ чиглэлээр санаачилга гарган идэвхитэй ажиллаж байна. Энэ нь нийгмийн хариуцлага бөгөөд аюул эрсдэл багатай санхүү, банкны үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбоотой чухал асуудал тул олон улсын банкууд ихээхэн анхаарал хандуулж байна.

Уурхайн хаалтын төлөвлөгөө нь үндсэндээ байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд суурьлан ашигт малтмалын ордын төрөл, уурхайн хэмжээ, хэлбэр, баяжуулах, боловсруулах үйлдвэрийн онцлогтой уялдан харилцан адилгүй агуулга бүтэцтэйгээр хийгддэг бөгөөд төлөвлөгөөний хамрах цар хүрээнээс шалтгаалан түүнд оролцох талууд, нөлөөлөлийн тогтоож хүлээн авах, хянах, батлах, хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн баталгаа зэрэг нь өөр өөр шаардлага тавигдах боломжтой болж байна.

Олон улсын санхүүгийн корпорациас төслийг байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллөөр нь А (нөлөөлөл ихтэй буюу засаж залруулах боломжгүй сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай), В (хариу арга хэмжээгээр засаж залруулж болох зарим сөрөг нөлөөлтэй), С (сөрөг нөлөөлөл маш бага юмуу бараг үгүй) гэсэн ангилалд хуваадаг байна.

Ашиглалтад өртөж буй орд болгонд хаалтын цогц асуудал тулгарна. Чиг баримтлал, хэрэгжүүлэх цаг хугацаа, орон зай, хөрөнгө хүч, хүрэх үр дүн талаасаа уурхай бүрийн хаалт давтагдашгүй шинжтэй байна.

Хаалтын төлөвлөгөө боловсруулах үе шат, хамрах цар хүрээ, агуулгыг харьцуулж үзвэл:

Хаалтын төлөвлөгөө боловсруулах үе шат, агуулга, бүтэц, шаардлага	Невада	ОХУ	Энэтхэг	Бритиш колумби	Баруун австрал	Чили	ӨАБНУ	Казахстан	Киргизстан	Индонез	Перу	Филиппин
Хаалтын шаардлага нөхцөлийг үнэлэх	x		x	x	x	x	x		x	x		
Хаалтын төлөвлөлтийн менежмент	x			x	x	x	x					
Нийтийн оролцоог үнэлэх	x			x	x	x						
Хаалтын концепц боловсруулах	x		x	x	x	x	x		x			
Хог хаягдлын төрөл, геохимийн үнэлгээ	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Геотехникийн онцлог	x	x	x	x	x	x	x	x	x			

Гидрологи ба гидрогеологийн үнэлгээ	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Сейсмийн үнэлгээ	x	x	x	x	x	x	x			x	x	x
Усны чанарын таамаглал	x		x	x	x	x		x	x		x	x
Хүрээлэн буй орчны үнэлгээ	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Гадаргын тогтворжилтийг үнэлэх	x	x	x	x	x	x	x		x	x	x	x
Олборлолтод өртсөн гадаргын хэлбэр, хэмжээ	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Хөрсний бүтэц	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Нөхөн сэргээлтийн дизайн	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Газрын хэлбэршүүлэлт	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Ус цэвэршүүлэх арга хэлбэр	x		x	x	x	x	x	x				
ус тусгаарлах нөхцөл дизайн	x											
Тусгаарлах замаар хаягдсан уурхай үүсгэх		x	x				x	x	x	x	x	x
Агаарын чанарын үнэлгээ	x		x	x	x	x	x			x	x	x
Дэд бүтцийн үнэлгээ, цаашид ашиглах нөхцөл боломж, шийдэл	x	x	x	x	x	x		x	x			
Хаягдлын аж ахуйн инженерийн бүтэц, шийдэл	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Уурхайн тоног төхөөрөмжийн шийдэл	x	x	x	x	x	x	x	x	x	x	x	x
Орон нутгийн ажиллах хүчний шийдэл	x		x	x	x	x			x	x	x	
Нөхөн олговор компенсаци			x	x	x	x						
Уул уурхайн дагасан биенес, эдийн засаг	x		x	x	x	x						
Ажиллах хүчний шийдэл	x		x	x	x	x						
Нийгмийн хүлээлт			x	x	x							
Хаалтын дараах газар ашиглалт	x			x	x	x						x
Санхүүгийн баталгаа	x		x	x	x	x	x	x				x
Даатгал	x			x	x							
Эрсдэлийн үнэлгээ	x			x	x	x						
Мониторинг	x		x	x	x	x	x			x		x

- Цианид, хүхрийн хүчил зэрэг хортой бодисоор уусгалт явуулсан овоолго, баяжуулах үйлдвэрийн хаядасны хураагуур байршуулсан талбайд аюултай болон хортой нөлөөлөл үүсгэж болзошгүй тул уг газарт нэгжийн үнэлгээг өндөр тогтооно.

Төлөвлөгөө батлах явц:

	А бүлэг	Б бүлэг
Боловсруулах нөхцөл, хугацаа	Харилцан адилгүй гол төлөв орд ашиглах ТЭЗҮ боловсруулах шатандаа ашиглалтын тусгай зөвшөөрөл болон Түрээсийн гэрээ байгуулах, төсөл хэрэгжиж эхлэхээс өмнө үнэлгээ хийж хаалтыг төлөвлөж эхэлдэг. Гэхдээ төслийн үргэлжлэх хугацаанаас хамааран богино хугацаатай бол төсөл эхлэхээс өмнө, урт хугацаатай бол төсөл эхлэхээс өмнө ерөнхий төлөвлөгөө хийж төслийн явцад нарийвчилсан төлөвлөгөөг хийж хүлээлгэн өгдөг.	Хуулинд тодорхой заагаагүй. Гол төлөв ашигт малтмалын олборлолтын явцад эсхүл түрээсийн гэрээ, ТЭЗҮ боловсруулсны дараа эсхүл, ордын нөөц дуусахаас тодорхой хугацааны өмнө боловсруулдаг. Зарим улс орнууд хаалтын талаар гэрээ байгуулдаг. Жишээлбэл ОХУ, Мексик, БНХАУ, Танзани, Киргизстан.
Хэн боловсруулах	Мэргэжлийн байгууллага, мэргэшсэн этгээд /хувь хүн/. Төслийн хэрэгжүүлэгч компани нь хаалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулах үүрэг хүлээдэг бөгөөд БОНБУ, ННБҮ-ийн үнэлгээ хуулиуд болон тусгайлсан хуулиудаар мэргэшсэн этгээд уг судалгааг хийж хариуцлага хүлээх субъект болохыг тусгайлан заасан байдаг.	Хэн боловсруулах талаар нарийвчлан заагаагүй. Энэтхэг улс гэхэд томоохон уурхайн хаалтыг төсөл боловсруулах ажлыг тендерээр шалгаруулдаг. Гол төлөв тухайн уул уурхайн компан өөрөө хариуцан боловсруулдаг бөгөөд мэргэжлийн этгээд болон мэргэжлийн байгууллагын талаар тусгайлан заагаагүй байдаг. Индонез, Перу зэрэг улс журманд өөрчлөлт оруулах замаар зарим шаардлага, нэмэлт хийж байна.
Мэргэжлийн байгууллага	Мэргэжлийн байгууллага хувийн хэвшлийн сайн дурын үндсэн нэгдсэн төрийн бус байгууллагуудын оролцоог эрхэмлэдэг. Олон жилийн туршлага, түүхэн уламжлалтай. Мэргэжлийн байгууллагуудын өөрсдийн санаачлага зонхилдог. Зөвхөн мэргэжлийн холбоо байгууллагуудаас гадна банкний систем банкны холбоодоос шаардлага тавьж ач холбогдол өгдөг. ОУИТБС-ын хүрээнд хариуцлагатай уул уурхайн чиглэлээр анхаарал тавьж байна.	Мэргэжлийн байгууллагууд нь чадавхижаагүй шинэ тутам. Сүүлийн жилүүдэд ОУИТБС-ийн хүрээнд дэвшилт, ахиц нилээд гарч байна.

Иргэний оролцоо хангасан байдал	Баруун австрал, онтарио, квенсланд зэрэг нь тухай төлөвлөгөөний анхны төсөл бэлэн болоход нээлттэй байдлаар цахимаар санал авч түүнийг хэлэлцүүлсний үндсэн дээр төслийг боловсруулдаг. Монтана, Невада, Бритиш колумби зэрэг нь уугуул иргэдийн асуудлыг онцгой анхаардгаас гадна иргэний нийгмийн байгууллагууд оролцоо, санаачлага хөгжсөн. Төлөвлөгөө боловсруулах явцдаа нээлттэй хэлэлцүүлэг заавал явуулдаг. Ontario, Manitoba-д агентлагийн захирал нь төлөвлөгөө баталдаг.	Энэ талаар хуульчилж нарийвчилан тусгаагүй. Харилцан адилгүй. Энэтхэг улс гэхэд нээлттэй хэлэлцүүлэг явуулах, нутгийн иргэд, ажиллагсдын нийгмийн асуудлыг тусгах талаар тусгасан байдаг. Филиппин, Киргизстан улс иргэний нийгмийн байгууллагын идэвхи оролцоо сайжирч байгаа бол, Лаос, Вьетнамд эрх зүйн сайжруулах замаар иргэний оролцоог хангах алхамууд хийж байна.
Орон нутгийн удирдлага	Холбооны улсуудын хувьд Муж улсын агентлаг, мужийн төрийн байгууллагуудын хяналт, зохион байгуулалт чухал бөгөөд төлөвлөгөөг хүлээн авах, хянах, хэлэлцүүлэх, батлах зэрэг нь тухайн мужийн захиргааны байгууллагууд хариуцан хэрэгжүүлдэг. Хяналт, хариуцлага, эрх олгох байгууллага орон нутгийн түвшинд байдаг.	Орон нутгийн оролцоо ялангуяа төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангуулах, нөхөн сэргээлтийг хүлээн нэгж нь орон нутгийн түвшинд байх бөгөөд орон нутгийн төлөвлөгөө боловсруулах үед хэлэлцэхээр гол төлөв заасан. Орон нутгийн эрх төлөвлөгөө батлах, санхүүгийн баталгаа гаргах асуудалд харьцангуй хязгаарлагдмал, санал өгөх хэмжээнд байдаг.
Агентлагийн эрх	Байгаль орчны агентлаг нь төлөвлөгөөг хүлээн авах хэлэлцэх, хянах, батлах бүх эрх мэдлийг эзэмших ба орон нутгийн агентлаг байна. Холбооны засгийн газар төв агентлагууд уг асуудлаар оролцдоггүй ба орон нутгийн агентлагуудыг хянах зэргээр оролцдог. Төлөвлөгөөний талаар хэдэн ч удаа татгалзах эрхтэй. Аризонад хаалтын асуудал хариуцсан хоёр агентлаг байгаа нь Аризонагийн Хүрээлэн буй орчны чанарын хэлтэс (ADEQ) ба Мужийн Уул уурхайн Хяналтын Оффис хэмээх байгууллагууд болно. ADEQ нь хүрээлэн буй орчинд үзүүлэх ерөнхий нөлөөлөлтэй (хөрс, ус, агаар) холбоотой асуудлыг хариуцаж байхад Уул уурхайн хяналтын оффис нь тухайн уурхайн аюулгүй байдлыг (хаалт хийгдсэн хаягдлын далангийн тогтворжилт, далд уурхайн малталтын аюулгүй байдал г.м) хариуцаж байна. Чилид SERNAGEOMIN буюу Үндэсний геологи, уул уурхайн агентлаг төлөвлөгөөг баталж, 5 жил тутамд аудит хийж шаардлагатай тохиолдолд төлөвлөгөө шинэчлэхийг шаарддаг. Невадад уул уурхайн зохицуулалт ба нөхөн сэргээлтийн товчоо/Bureau of Mining regulation and reclamation/ асуудлыг хариуцдаг.	Төлөвлөгөөг хянах, хүлээн авах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих эрхийг эдэлдэг. Орон нутагтай хамтарсан байдлаар хэрэгжилтийг хангуулдаг. Төлөвлөгөөг хүлээн авах гол субъект болдог. Казахстан улс хүрээлэн буй орчны агентлагийн дэргэдэх зөвлөл төлөвлөгөө батлах эрхийг эдэлдэг. Индонез-д гэхэд муж дамнасан, хорт бодис бүхий, эсхүл гадны хөрөнгө оруулалттай, төрийн өмчийн уурхайг хаах асуудал нь төв засгийн газарт, тухайн муж бүхэлдээ багтах, дотоодын хөрөнгө оруулалттай бол тухайн орон нутгийн агентлаг хаалтыг хариуцдаг. Хаалттай холбогдон аль тохиолдолд ерөнхий төлөвлөлтийн агентлаг, хүрээлэн буй орчны агентлаг төлөвлөгөөг хянах, санхүүгийн баталгааг зөвшөөрөх эсэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Яамны эрх	Бодлогын талаас гол анхаарах ба давхар хяналт тавих, төлөвлөгөөг батлах, зэрэгт оролцоно. Зарим улс орнуудад агентлаггүй тохиолдолд тухай яамны өөрөө бүрэн хариуцаж хэрэгжилтийг хангадаг. Агентлагийн баталсан төлөвлөгөөг давхар хянах эрхтэй. Баруун австралд гэхэд байгаль орчны тухай хуулийн дагуу Байгаль орчны сайд, Уул уурхайн хуулийн дагуу уул уурхайн сайд батлахаар заасан. Төлөвлөгөөг батлах батлахгүй байх бүх эрхийг эзэмшихээс гадна хэдэн ч удаа төлөвлөгөөг буцааж болно. Өмнөд австралд Үйлдвэрлэл, инноваци, худалдаа, баялаг, эрчим хүчний яам гол зохицуулагч болдог.	Уул уурхайн асуудал хариуцсан яам, байгаль орчны асуудал хариуцсан яамдууд гол эрх, үүрэгтэй байдаг бол индонезд уул уурхайн байгаль орчны яамаас гадна Нийгмийн хамгааллын яам, Ойн яам төлөвлөгөөг хянаж баталдаг. Харин Филиппин улсын хувьд Уул уурхайн яамны дэргэдэх байгаль орчны яам, шинжлэх ухаан технологийн яам, сангийн яам, орон нутаг, эдийн засаг хөгжлийн агентлагийн төлөөлөлийг багтаасан зөвлөл /MICC/ -оор хэлэлцүүлэн баталдаг. Өмнөд Африкт хаалтын гэрчилгээ нь эрх бүхий бусад тохиолдолд гаргасан болон Усны хэрэг, Ойн газар усны нөөц нь эрүүл мэнд, аюулгүй байдал, гарч болзошгүй бохирдлын менежментийн холбоотой заалтыг авч байна гэсэн бичгээр батлагддаг болно
Төлөвлөгөөний нээлттэй байдал	Баруун австралд Төлөвлөгөөг цахимаар болон CD-ROM-оор ирүүлж нээлттэй бахим хуудсанд байршуулж судлаач, ард иргэдийн саналыг авдаг. Төлөвлөгөө батлах процедур харьцангуй урт бөгөөд ард иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгэ хийж саналыг авах, уугуул иргэдийн зөвшөөрөл авах, боловсруулсан төслөө нээлттэй цахим болон бусад хэлбэрээр хэлэлцүүлэх, орон нутгийн болон засгийн газрын байгууллагуудын санал болгосноор чөлөөт судлаачдаар шинжээч, эксперт хийлгэх, төрийн байгууллагуудын тухайн асуудал хариуцсан албан хаагчийн саналыг авч хэлэлцэн тусгах зэргээр урт хугацаанд нээлттэй хэлэлцсэний үндсэн дээр төлөвлөгөөг баталдаг.	Улс болгонд өөр бөгөөд нийтлэг зохицуулалт нь уурхайн хаалттай холбоотой эрх ашиг нь хөндөгдөж буй талуудын саналыг авах талаар заасан байх бөгөөд эрх ашиг хөндөгдөж буй этгээд гэдгийг тодорхойлж, оролцуулах механизмын талаар хангалттай бус тусгасан байна. Филиппинд Уул уурхайн үйлдвэрлэлийн зохицуулах зөвлөл /MICC/ нь ил тод байдлыг хангах үүднээс хуралдаандаа ОУИБС-аас судлаач, гишүүнийг 6 сарын хугацаагаар гишүүнээр ажиллуулдаг. Мөн бизнес, шинжлэх ухаан, иргэний нийгмийн төлөөлөгчийн гишүүнээр ажиллуулж болхоор заасан байдаг.
Батлах процедурын хугацаа	Батлах хугацаа нь харилцан адилгүй бөгөөд 5 хүртэлх жилээр үргэлжилдэг. Гол нь талуудын оролцоо, нээлттэй, ил тод байдлыг хангадаг. Баруун австрал, квенсландад 5-10 жилийн турш хянах ч тохиолдол бий. Төсөл хэрэгжихээс өмнө гол төлөв баталдаг тул хаалтын асуудлаа шийдэх нөхцөлөө судалж төлөвлөгөө батлах нь өөрөө нийгмийн зөвшөөрөл болдог бөгөөд нийгмийн зөвшөөрөл авч чадахгүй, уурхайн хаалт, ТЭЗҮ батлагдалгүй 20 гаруй жил болж байсан тохиолдол ч байдаг.	Хугацааны хувьд янз бүр филиппин улсад 6 сарын хугацаанд зөвлөл хэлэлцэн баталдаг бол Индонез-д санхүүгийн баталгаа байршуулснаас 3 сарын дотор. Гол төлөв төлөвлөгөөг боловсруулснаас хойш 1 жилийн дотор хэлэлцэж, хянаж баталж амждаг. Замби, Ботсван, Узбекистан, Экватор, Киргизстан, Папуа шинэ гвиней зэрэг улсад 1-3 сард багтаан баталдаг.

Санхүүгийн баталгаа	Санхүүгийн баталгааг гол төлөв хуульчилж өгсөн байдаг. Баталгааг бонд, банкны барьцаа, батлагаа, чек, үнэт цаас, хугацаат хадгаламж, засгийн газрын бонд, бэлэн мөнгө, даатгал зэрэг хэлбэрээр байршуулхаар заасан байдаг. Мөн үүнээс гадна мэргэжлийн холбоо, компаниудын өөрсдийн санал санаачлагаар үүсгэн байгуулагдсан мэргэжлийн байгууллагын дэргэд сан байдлаар байршуулах, үндсэн бонд баталгааны гадна давхар, даатгал, сан үүсгэх арга хэлбэрүүдээр санхүүгийн баталгааг гаргадаг. Гэхдээ Квебек, Саскатчеван, Калифорн, Нью мексик, Аризона, Юта, Монтана зэрэгт бонд, санхүүгийн баталгаа байршуулах талаар зохицуулалт байхгүйгээс олон тооны уурхайн хаалтын төлөвлөгөө хэрэгжилгүй орхигдсон уурхай үүс сэн байдаг.	Уул уурхайн шинэ зохицуулалттай Б бүлэгт хамаарч байгаа орнуудын хувьд шинэ дэвшилттэй ололтой арга хэмжээнүүдийн байнга авсаар ирж байгаа бөгөөд Индонез, Казахстан, Энэтхэг, БНХАУ, Буркино Фасо, Зааны ясан эрэг улсууд санхүүгийн баталгаа байршуулах талаар хуульчилсан байдаг. Эдгээр харин Казахстан нь баруун австралтай төстэй буюу тухай жилийн зардалын 1 хувьтай тэнцэх хувиар байна гэсэн байхад. Индонез, Энэтхэгт хаалтын төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааны хэмжээ цар хүрээнд тулгуурлан тооцох, ОХУ, БНХАУ, Киргизстан нь хэлэлцээр хийх, гэрээ байгуулах замаар тохиролцохоор заасан.
Хяналт тавих этгээд	Төлөвлөгөө хүлээж авах хянах, батлах процедур нь бүхэлдээ нээлттэй байхыг шаарддаг бөгөөд иргэд, иргэний нийгмийн байгууллага, төр, орон нутгийн хамтын хяналтын дор төлөвлөгөө батлагддаг. Гэхдээ Муж улс бүрийн эрх зүйн зохицуулалтаас шалтгаалан ялгаатай зохицуулалттай байдаг. Жишээлбэл: Невадад уул уурхайн зохицуулалт ба нөхөн сэргээлтийн товчоо/Bureau of Mining regulation and reclamation/ асуудлыг хариуцдаг. Онтарио, Манитоба, Бритиш колумбид хүрээлэн буй орчны агентлаг гол хариуцагч этгээд болохоос гадна уул уурхай, багаль орчны хяналтын байцаагч нь төлөвлөгөө болон санхүүгийн баталгаанд хяналтаа тавьдаг. Чилид Үндэсний геологи, уул уурхайн агентлаг төлөвлөгөөг баталж, 5 жил тутамд аудит хийж шаардлагатай тохиолдолд төлөвлөгөө шинэчлэхийг шаарддаг.	Улс бүр ялгаатай байдлаар зохицуулалт хийсэн байдаг бөгөөд нийтлэг зүйл нь хаалтын төлөвлөгөөг батлах явцад эрх ашиг хөндөгдөх этгээд санал өгөх эрхтэй байхаас гадна, агентлагийн үйл ажиллагааг яам харьяа дээд байгууллага нь мужийн байгууллагын шийдвэрийг төв засгийн газрын агентлаг хянах эрхтэй. Хаалтын төлөвлөгөөний биелэлтэд тухай орон нутгийн агентлаг голчлон хяналт тавьдаг бол ОХУ, БНХАУ-д мэргэжлийн хяналтын байцаагч нь төлөвлөөний хэрэгжилтийг хянаж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох эрхтэй. Индонез-д төлөвлөгөөний хэрэгжилт төлөвлөсөн цаг хугацааны гүйцэтгэлээс 60 хувиар бага байх тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцалж санхүүгийн баталгааг хураан авч гуравдагч этгээдээр хаалтыг хийлгэдэг.

Хаалтын төлөвлөөг хүлээн авах, хянах, батлах процессийг улс тус бүрээр авч үзвэл харьцангуйгаар нэгдсэн нэг ойлголт чиглэж байгааг харж болох хэдий ч төрийн байгуулалтаас ихээхэн хамаарч байгаа байна. Хаалтын төлөвлөөг шаардлагын талаар болон иргэний нийгмийн оролцоо зэрэг нь ОУИТБС зэрэг олон улсын сайн туршлага, санаачлага бодит ажлуудаас үүдэн нэгдсэн нэг ойлголттой болж эхэлж байна.

	Невада	Бритиш колумб	Онтарио	Баруун австрал	Өмнөд австрал	Чили	Казахстан	Индонез	ОХУ	Энэтхэг	Филиппин	Монгол
Хаалтын ерөнхий төлөвлөгөө ирүүлэх эсэх	*	@	#	@	#	@	&	#	&	&	&	&
Уурхайн хаалтаас өмнө Хаалтын нарийвчилсан төлөвлөгөө ирүүлэх хугацаа эсхүл төлөвлөгөөг шинэчлэх хугацаа	5	5		3	3	5		5			2	
хаатын төлөвлөгөөг хүлээн авах этгээд	b	a	b	a	a	b	b	a	c	a	d	b
уурхайн орчимд амьдардаг иргэд төлөвлөгөөнд санал өгөх эрхтэй эсэх	+	+	+	+	+	+	-	+	-	+	-	-
Иргэний нийгмийн байгууллагын оролцоо журамласан эсэх	+	+		+	+	+	-	+/+	-	-	+/-	
Уугуул иргэдийн асуудал	+	+	+									
Төлөвлөгөөг хэлэлцүүлдэг эсэх		+	+			+				+		
Төлөвлөгөөг хянах, батлах явц нээлттэй эсэх	+	+	+	+	+	+	-	-	-	+/-	-	
Төлөвлөгөө батлах субъект	b	a	b	a	a	b	b	a	c	a	d	d
Санхүүгийн эх үүсвэр, баталгаа байршуулах талаар журамласан эсэх	+	+	+	+	+	+	+	+	+/-	+	-	-

* бие даасан хуулиар ус, хог хаягдал гэх мэтээр урьдчилсан хаалтын ерөнхий төлөвлөгөө ирүүлдэг, # бие даасан ерөнхий төлөвлөгөө төсөл эхлэхээс өмнө ирүүлдэг, @ төсөл эхлэхээс өмнө төлөвлөгөө ирүүлдэг, & ерөнхий төлөвлөгөө ТЭЗҮ-ийн агуулгад багтаан ирүүлдэг.

a- яам, b- агентлаг, c-орон нутаг, d- бие даасан зөвлөл
+зохицуулсан, -зохицуулалтгүй

Зарим улсын хаалтын төлөвлөгөөг хүлээн авах процедурын талаар нарийвчилсан авч үзвэл:


БАРУУН АВСТРАЛ:

Баруун австралд Уул уурхайн хууль, Байгаль орчны үнэлгээний хуулийн хүрээнд 2011 онд баталж 2015 онд нэмэлт өөрчлөлт хийсэн “Уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах заавар/Guidelines for preparing Mine Closure Plans/ болон “Уурхайн хаалтын төлөвлөгөөний удирдлага /Administration of mine closure plans/” баримт бичгүүдийн хүрээнд зохицуулагддаг.


Аж ахуйн нэгж байгууллага нь Уул уурхай, газрын тосны яам/Department of Mines and Petroleum/-ийн цахим хуудсанд (<http://www.dmp.wa.gov.au/>) хандан Хүрээлэн буй орчны хэлтэс /environmental division-тэй холбогдон ашигт малтмалын өргөдөл, эрэл-хайгуулын

ажлын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, газрын тосны тайлан, мэдэгдэл зэргийг дүртгүүлэх боломжтой. Үүнд дараах дарааллаар бүртгүүлнэ.

1. Цахим хуудсанд нэвтэрч өргөдөл ба бичиг баримт гэсэн баннерт хүрээлэн буй орчин гэдгийг сонгоно зураг-3.



2. Өргөдөл бичиг баримт, мэдэгдэл, төлөвлөгөө, тайлангийн аль болохыг сонгоно. (зураг-4)



3. Цаим хуудас нь тухайн бичиг баримтын төрлөөс шалтгаалан бүрдүүлэх материал өргөдлийн шаардлага, бичиг баримт тус бүрээр харуулах энэхүү загварыг татан авч загварыг дагуу бэлтгэсэн байхыг шаардана.(зураг-5)

Programme of Work Prospecting (PoW - P)

Programme of Work - Prospecting (PoW-P) applications and Prospecting Rehabilitation Reports can be lodged in hardcopy format or online via DMP submissions. Read our [guide](#) for how to submit your applications and reports online via DMP Submissions.

Submit PoW - P application online **POW-P APPLICATION**

Submit Prospecting Rehabilitation Report online **REHABILITATION REPORT**

Programme of Work - Prospecting Rehabilitation Report - 110 Kb
Prospecting Rehabilitation Report

Programme of Work - Prospecting (PoW-P) Application Form - 379 Kb
PoW-P application

Programme of Work - Prospecting Policy - 169 Kb
This document provides a framework for the application and assessment of a Programme of Work - Prospecting (PoW-P).

4. Тухайн хэрэглэгч өөрийн бүртгүүлсэн нууц үг, цахим хамгаалалт/security/-ын шаардлагыг хангах ба энд анхлан бүртгүүлэх, бүртгүүлсэн хэрэглэгч, зочин хэлбэрээр бүртгүүлэх боломжуудыг хангасан байх бөгөөд бүртгүүлэхэд гол анхаарах зүйл нь тухайн хүний цахим-шуудангийн хаяг хүчинтэй эсэхийг нягтладаг.
5. Бүртгүүлж нэвтэрснээр УУГТЯ-ны холбогдох хэлтэс цахим шуудан явуулах боломж бүрдэх ба та өөрийн өргөдөл, тайлан төлөвлөгөө, мэдэгдэл зэргийг хавсарган явуулснаар хүрээлэн буй орчны холбогдох хэлтсийн мэргэжилтэнд шууд уг е-мэйл/цахим шуудан хүрэх бөгөөд хариуцсан мэргэжилтэн танд хариу өгөх болно. (зураг-6)

Response Details

Message

Please find attached my updated application.


Attachments

Attach file

Send me a copy: ☒

Assign Send Cancel

DMP буюу УУГТЯ-ны холбогдох мэргэжилтэн уг төлөвлөгөөг хүлээн авснаар хянах процесс эхлэх ба дараахь схемийн дагуу явагдана.



Зураг 7. Төлөвлөлтийн үе шат нь хайгуулын үе шатнаас уурхайн төлөвлөлт, дизайны үе шат хүртэл үргэлжлэх ба ТЭЗҮ болон БОНБУ батлагдсаны дараа төлөвлөгөөг боловсруулж дуусган хүлээлгэн өгдөг. Хаалтын төлөвлөгөө батлагдснаас хойш байнга шинэчлэж, аудит хийж байдаг.

Хаалтын төлөвлөгөөг үнэлэх, түүнд оролцогч тал/stakeholder/-уудын саналыг тусгах талаар өмнө байнга дурьдагдсаар ирсэн бөгөөд Баруун австралийн жишээнээс үзэхэд Оролцогч Тал гэдэгт:

Компаний дотоод оролцогч тал:

- Уурхайн менежер,
- Уурхайн төлөвлөгчид,
- Инженерүүд,
- Техникийн ба үйл ажиллагааны шийдэл гаргах болон уурхайн төлөвлөлттэй холбоотой ажилтан албан хаагчид хамаарна.

Гадаад оролцогч тал:

- Засгийн газар/яам, агентлаг, орон нутгийн байгууллага/,
- Хаалтын дараах газар эзэмшигч, менежер /уугуул оршин суугч, газар эзэмшигч, түрээслэгч, бэлчээрийн газрын удирдлага, улсын газрын асуудал хариуцсан албан хаагч, байцаагч/,
- Иргэний нийгмийн байгууллага сонирхож буй ТББ

- Зэргэлдээ хөрш газрын эзэмшигч
- Гадаргын болон газар доорхи урсгалын доод хэсэгт байрлах ус ашиглагч этгээдүүд хамаарна.

Уурхайн хаалтын төлөвлөгөөнд гол оролцогч тал гэдэг нь хаалтын дараа тухайн газрыг эзэмшигч, төрийн байгууллагын тухайн асуудал хариуцсан албан ташаалтан байх ба тэдгээрийн санал нь төлөвлөгөөнд заавал туссаны үндсэн дээр төлөвлөгөөг баталдаг байна.

Төлөвлөгөөг батлахад төлөвлөгөөнд суурь үзүүлэлт болон БОНБУ-ний үр дүнд үүсэж нөхцөл байдлыг харьцуулан гарах үз дагаварыг оновчтой шийдвэрлэх төлөвлөлт байхыг шаарддаг ба хаалтын төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт нь SMART/SMART зарчимд суурьласан байх бөгөөд энэ нь УУГТЯ болон БОХА-аар хүлээн зөвшөөргдсөн байна.

SMART зарчим гэдэг нь Specific, Measurable, Achievable, Relevant, Time bounding гэсэн үгний товчлол ба энэ дараах утга санааг багтааж байна. Үүнд:

- **Specific/өвөрмөц:** байгаль, нийгэм, эдийн засгийн дахин давтагдашгүй өвөрмөц байдлыг тусгасан байх;
- **Measurable/Хэмжигдэхүйц:** тухайн нөхөн сэргээлтийг харуулахын тулд аналог үзүүлэлтэд чиглэсэн хандлагатай байх;
- **Achievable/Хэрэгжихүйц:** хэмжиж буй шалгуур нь хэрэгжихүйц буюу бодит байх;
- **Relevant/Зорилгод нийцсэн:** Зорилтуудыг хөндөлгүйгээр нөхцөл байдал өөрчлөгдөж эрсдэл үүсэхэд зохицуулж болохуйц уян хатан шинжтэй байх;
- **Time-bound/Цаг баримталсан:** Газрыг буцааж хүлээлгэн өгөх зохимжит, төлөвлөсөн цаг хугацаанд нь хэрэгжиж, хянагдахуйц байх

Энэхүү зарчим нь хаалтын төлөвлөгөөний үр дүн буюу хаалтын дараах газар ашиглалт, үлдэх объект, газрын хэлбэр дүрс, экосистемийн нөлөөлөл тус бүр болон хамтдаа баримтлагдсан байхаар төлөвлөх нь төлөвлөгөөг үнэлэхэд чухал ач холбогдолтой болгодог. Мөн хаалтын дараах мониторинг, үйлчилгээ нь хаалтын төлөвлөгөөний чухал үзүүлэлт болдог ба тасралтгүй буюу тодорхой давтамжтай сорьцлолт, хяналт, туршилтын ажлууд холбогдох арга, аргачлал стандартын дагуу хийгдэхээр төлөвлөгдсөн байх, сорьцлолт хяналтын ажлаар эрсдэл ихтэй, төлөвлөгөөний дагуу зүйл илрэх, гамшиг болох зэрэг гамшигийг устгах төлөвлөгөөтэй байх талаар чухал асуудлыг цогцоор нь авч үзсэн хэсэг байдаг нь төлөвлөгөөг батлах, үнэлэх гол хүчин зүйл болдог ба оролцогч талуудаас ч ихээхэн урьдчилан сэргийлэх, сайжруулах хүсэлтүүдийг тавьдаг байна.

Төлөвлөгөө батлах субъект болох УУГТЯ нь энэ бүгдийг харгалзсны үндсэн дээр төлөвлөгөөг баталж цаашид аудит хийж сайжруулах, шинэчлэх, явцын илэрч буй төлөвлөгдөөгүй болон шинээр бий болсон нөхцөл байдлуудын талаар авч үзэх зэргээр олборлолтын үйлдвэрлэл дуустал хугацаанд төлөвлөгөө нь засагдаж, сайжирч байдаг. Нэмэлт засвар, шинэчлэлийг 3 жил тутамд судалгаа, аудит дээр үндэслэн хийж төлөвлөгөөнд тусгах эсэх талаар оролцогч талуудын саналыг авч УУГТЯ болон БОХА-аар батлуулдаг байна. Төлөвлөгөө батлах хугацаа нь 5-10 жил болох нь байдаг бөгөөд үнэлгээ хийх явцад оролцогч талуудын санал бүрэн туссан, SMART зарчмыг баримталсан байхыг шаарддаг.

Төлөвлөгөөг баталсан хяналтын хуудасны дагуу холбогдох албан хаагч үнэлж санал, зөвлөмж, шаардлага тавьдаг байна. Хяналтын хуудасны загварыг дор үзүүлбэл:

№		Тийм/үгүй хариултгүй	Хуудасны дугаар	Санал шүүмж	Өмнөх хувилбараас өөрчилсөн эсэх (Т/Ү)	Хуудасны дугаар	Дүгнэлт
	Уурхайн хаалтын төлөвлөгөөний хяналтын хуудас						
1	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч эсвэл уурхайн үйл ажиллагаа эрхлэгч компанийг бүрэн төлөөлөх эрх мэдэлтэй этгээд энэхүү хяналтын хуудсыг баталгаажуулж, гарын үсгээ зурсан үү?						
Ил тод байдал							
2	2015 оноос эхлэн уурхай хаах төлөвлөгөөнүүдийг олон нийтэд ил тод мэдээллэдэг болсоныг та мэдсэн үү?						
3	Тус уурхай хаах төлөвлөгөөнд олон нийтэд мэдээллэж болохгүй мэдээлэл багтсан үү?						
4	Хэрэв 3-р асуултанд 'тийм' гэж хариулсан бол, нууцлавал зохих мэдээллүүдийг тусад нь хавсаргаж ирүүлсэн үү?						
Төлөвлөгөөний нүүр хуудас, гарчиг							
5	Дараах мэдээллүүдийг уурхай хаах төлөвлөгөөний нүүр хуудсанд тусгаж өгсөн үү?						
	• Төслийн нэр						
	• Компанийн нэр						
	• Холбоо барих хаяг (утасны дугаар, имэйл)						
	• Бичиг баримтын дугаар, хэд дахь хувилбар болох тухай мэдээлэл						
	• Төлөвлөгөөг хүргүүлсэн огноо (хяналтын хуудсыг баталгаажуулж, гарын үсэг зурсан огноотой мөргөх ёстой)						
Зорилго, цар хүрээ							
6	Уурхай хаах төлөвлөгөө хүргүүлж буй шалтгаан (жишээ нь, уурхайн ерөнхий төлөвлөгөөний бүрдэл хэсэг болгож, уурхай хаах төлөвгөө шинэчлэгдсэн учир, бусад хууль, дүрмийн шаардлагын дагуу)						
Төслийн товч танилцуулга							
7	Төслийн товч танилцуулгад дараах мэдээллүүдийг тусгасан үү?						
	• Газар эзэмшигчдийн мэдээлэл (түүнчлэн, газар, байгалийн нөөцийн зохицуулалт хариуцсан төрийн агентлагуудын нэрс; төслийн талбай болон түүний ойр орчимын газар нутгийг ямар зорилгоор ашиглаж байгаа тухай)						
	• Төслийн талбайн байршил						
	• Төслийн талбайн зохион байгуулалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө						
	• Төслийг хэрэгжүүлж ирсэн түүх болон төслийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх ерөнхий мэдээлэл						
Үүрэг хариуцлага, амлалтууд							
8	Уурхайг хаахтай хобоотойгоор хүлээсэн үүрэг хариуцлага, өгсөн амлалтуудын талаар төлөвлөгөөнд тусгасан үү?						
Төсөлд оролцогч талуудын хамтын ажиллагаа							

9	Уурхайг хаах үйл ажиллагаанд оролцогч талуудыг бүрэн гүйцэд тодорхойлсон үү?						
10	Төсөлд оролцогч талуудын хамтын ажиллагааны дэлгэрэнгүй бүртгэлийг уурхай хаах төлөвлөгөөнд тусгасан үү? Энд, хэлэлцсэн асуудал, гаргасан шийдвэр зэргийг нарийвчлан тусгасан байна.						
11	Төсөлд оролцогч талуудын цаашдын харилцааг ямар зарчимаар зохицуулах тухай төлөвлөгөөнд тусгасан үү?						
Уурхайг хаасны дараах газар ашиглалт							
12	Уурхайг хаасны дараах газар ашиглалтын төсөл, уг төслийг хэрэгжүүлэх хүрээнд дэвшүүлсэн зорилтууд, ландшафтын зураг төсөл зэргийг төлөвлөгөөнд тусгасан үү?						
13	Уурхайг хаасны дараах газар ашиглалтанд сөргөөр нөлөөлөхүйц байгаль орчинд үүссэн, эсвэл үүсэж болзошгүй доройтлуудыг (шишээ нь, бохирдсон талбай г.м.) бүрэн тодорхойлсон үү?						
14	Уурхайн үйл ажиллагааны явцад үүссэн, эсвэл үүсч болзошгүй хөрсний болон гүний усны бохирдлыг <i>Бохирдсон Талбайн Журам 2003</i> баримт бичигт тусгасаны дагуу Байгаль Орчины Бодлого Зохицуулалтын Хэлтэст мэдээлсэн үү?						
Уурхай хаах шалгуур үзүүлэлтүүд							
15	Уурхайг хаах үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх, түүнчлэн уурхайг бүрэн гүйцэд хааж дууссаныг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийг төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан үү?						
Өгөгдөл цуглуулах, өгөгдлийн дүн шинжилгээ							
16	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх суурь үзүүлэлтүүдийг (уурхай эхлэхийн өмнөх суурь судалгаанууд, байгаль орчины урьдчилсан үнэлгээ г.м.) төлөвлөгөөнд тусгасан үү?						
17	Эд материалуудыг холбогдох стандарт, журмуудад (жишээ нь, Үйлдвэрлэлийн Хүчиллэг Ус Зайлуулах Нийтлэг Журам) нийцүүлэн ангилсан үү?						
18	Бусад ижил төстэй уурхайнуудтай харьцуулан жиших замаар уурхайг хаах явцад тулгараж болзошгүй хүндрэл, бэрхшээлүүдийг тодорхойлсон үү?						
19	Уурхайг хаах үйл ажиллагааны хүрээнд дэвшүүлсэн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлөхүйц хүчин зүйлүүдийг (жишээ нь, бохирдлын нөлөөлөл) төлөвлөгөөнд бүрэн тусгасан үү?						
20	Уурхайн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг хаахтай холбоотой мэдээллүүдийг төлөвлөгөөнд нарийвчлан тусгасан үү?						
Эрсдлийн удирдлага							
21	Уурхай хаах төлөвлөгөөний хүрээнд, уурхайн дэд бүтцийн бүрэлдэхүүн тус бүрийг хаахад шаардагдах мэдээлэл, мэдлэгийг хангалттай бүрдүүлсэн эсэхийг шинжилж, эрсдийн үнэлгээг хийсэн үү?						
22	Төлөвлөгөөнд эрсдлүүдийг олж илрүүлэх, хянах үйл ажиллагааны үе шат, аргачлал, тэдгээрийн үндэслэлүүдийг тусгасан үү?						
Уурхай хаах үйл ажиллагааны хэрэгжилт							

23	Уурхайн тодорхой хэсгийг, эсвэл уурхайг бүхлээр нь хаах үйл ажиллагааны хүрээнд хийгдэх ажлуудын нарийвчласан төлөвлөгөө, тэдгээрийг хэрэгжүүлэх стратегийг төлөвлөгөөнд тусгасан уу?						
24	Уурхайн дэд бүтцийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг хаахад зориулсан ажлын төлөвлөгөөнүүд төлөвлөгөөнд тусгагдсан уу?						
25	Уурхайн нөхөн сэргээлтийн төсвийг тооцох журмын 1-р маягтанд тусгагдсан, уурхайн үйл ажиллагаанаас үүдэх сөрөг үр дагвар нэг бүрийн нөлөөллийн цар хүрээг уурхайн дэвсгэр зурган дээр буулгаж төлөвлөгөөнд хавсаргасан уу?						
26	Уурхай хаах төлөвлөгөөнд аливаа судалгааны болон туршилт аргачлалын ажлуудын календарчилсан төлөвлөгөө тусгагдсан уу?						
27	Уурхайн нөхөн сэргээлттэй холбоотой авах арга хэмжээнүүдийн календарчилсан төлөвлөгөөг уурхай хаах төлөвлөгөөнд тусгасан уу?						
28	Уурхайг хаах явцад үүсэж болзошгүй төлөвлөгөөгүй нөхцөл байдлыг хэрхэн даван туулах, хяналтандаа авах талаар төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгасан уу?						
29	Уурхайн үйл ажиллагааг бүрэн гүйцэд зогсоох ажлын календарчилсан төлөвлөгөөг уурхай хаах төлөвлөгөөнд тусгасан уу?						
30	Уурхайг хаах үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт, уурхайг хаасны дараах хадгалалт хамгаалалтын ажлуудын календарчилсан төлөвлөгөөг уурхай хаах төлөвлөгөөнд тусгасан уу?						
Уурхайг хаах үйл ажиллагааны хяналт, хадгалалт хамгаалалт							
31	Уурхайг хаах үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт, уурхайг хаасны дараах үзлэг шалгалт, хадгалалт хамгаалалтыг хэрэгжүүлэх аргачлал, чанарын хяналт, стратеги зэргийг багтаасан цогц тогтолцоог хэрхэн бүрдүүлэх талаар төлөвлөгөөнд тусгасан уу?						
Уурхайг хаах үйл ажиллагааны санхүүжилт							
32	Уурхайг хаах үйл ажиллагаа болон уурхайг хаасны дараах үзлэг шалгалт, хадгалалт хамгаалалтын ажлын зардлыг тооцоо, зардал тооцсон үндэслэлүүд, санхүүжилтийн эх үүсвэр зэргийг төлөвлөгөөнд тусгасан уу?						
33	Уурхайг хаах ажлыг хэвийн хэмжээнд, тасралтгүй санхүүжүүлж байгаа эсэхэд хяналт тавих тогтолцоог төлөвлөгөөнд тусгасан уу?						
Мэдээллийн бүртгэл хөтлөлт							
34	Уурхайн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, өгөгдөл бүрийг бүртгэн хөтлөх, хадгалан хамгаалах тогтолцоог хэрхэн бүрдүүлэх, энэ тал дээр уурхайн удирдлагын зүгээс ямар бодлого баримтлах тухай төлөвлөгөөнд тусгасан уу?						

БРИТИШ КОЛУМБ:

Канадын хамгийн баруун захын уул уурхай өндөр хөгжсөн бүс нутаг бөгөөд 1967 онд БОНБУ-ний хуулинд уурхайн хаалтыг зохицуулж өгснөөр Канад улсдаа анхдагч уурхайн хаалтын эрх зүйн орчин бий болгосон муж болсон байдаг.

1991 онд Эрчим хүч, уул уурхайн яам уурхайн хаалтын асуудлаар ард иргэд, бизнес эрхлэгч, төрийн байгууллагуудын дунд өргөн хэмжээний хэлэлцүүлгэ явуулсны үр дүнд 1995 онд Цагаан морь санаачлага /Whitehorse initiative/-аас уул уурхайн зөвлөх консул/Advisory council on mining/-ыг байгуулсан ба уурхайн хаалтын бодлогын чиглэлээр идэвхитэй ажиллаж уул уурхай бол газрыг тодорхой хугацаанд ашиглаж уул уурхайн үйл ажиллагаа дуустал газар, ус, байгаль орчныг нөхөн сэргээж нийгэмд хүлээлгэн өгөх бохирдуулсныхаа төлөө төлбөр төлөх талаар журамлах болсон. Үүний үр дүнд уг журам нь Уул уурхайн хуулийн хүрээнд Хөдөлмөр, хөрөнгө оруулалтын яам, Усны менежментийн хууль, Усны хууль, Онгон байгалийн тухай хууль, Газрын тухай хуулийн хүрээнд Байгаль орчны яам оролцох зөв юм гэж үзсэн байдаг.

Хөдөлмөр, хөрөнгө оруулалтын яам нь уурхайн хаалтын төлөвлөгөөг батлахад оролцох болсон шалтгаан нь хэрэв компани уурхайн хаалт хийж чадахгүй хүрэх, компани дампуурах тохиолдолоос сэргийлэх баталгаа болох бөгөөд одоо Бритиш колумбын уг сан нь хаалтын баталгаа болгож 350 сая долларын облигаци, 137 сая долларын хуримтлал үүсгээд байна.

Уурхайн хаалтын төлөвлөгөөг олборлолтыг эхлэхээс өмнө хэрэв эхэлсэн уурхайн бол шинэ хууль журмын дагуу яаралтай шинэчлэн ирүүлэх ёстой бөгөөд төсөл эхлэхээс өмнө тухайн ордыг ашиглах төлөвлөгөө, БОНБУ-ний хамтаар өргөдөлд хавсарган ирүүлнэ. Хаалтын төлөвлөгөө нь богино хугацааны буюу үйл ажиллагааны түр зогсолт/түр хаалт/, үндсэн хаалтын төлөвлөгөө/conceptual mine closure plan/ гэж ангилдаг байна.

Эрчим хүч, уул уурхайн яамны Бүс нутгийн уурхайн хөгжлийн хяналтын комисс болон/эсхүл Томоохон уул уурхайн төслийн газарт хоёуланд нь өргөдөлийг ирүүлэх ба ЭХУУЯ болон БОЯ нь төлөвлөгөө ирүүлсний дараа тусгайлсан мэдээллэл хүсэхээс илүүтэйгээр уурхайн хаалтын төлөвлөгөө ирүүлхээс өмнө ажлын цар хүрээ, нарийвчилсан мэдээллийн талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулахыг дэмжиж ажилладаг.

Уул уурхайн хуулийн хүрээнд зөвшөөрөл олгохдоо төслийн үе шат, нарийвчилсан инженер дизайн, менежментийн төлөвлөгөө, мониторингийн хөтөлбөрийг өргөдөлд ирүүлэх ба нийгмийн болон уурхайн ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, уул уурхайн үйл ажиллагаанд өртөх газар нутаг, усны урсацийн хамгаалалт, нөхөн сэргээлтийн талаар хангалттай дэлгэрүүлсэн байхыг шаарддаг.

БОЯ-ны зүгээс БОНБУ-ний техникийн үнэлгээний тайлангийн шаардлагатай холбоотой мэдээлэл, түүний заавар, удирдамжийг хангасан өргөдөлийг хүлээн авч бохир усны урсац, ус ашиглах зөвшөөрлийг өгдөг. Ялангуяа өргөдөл түүний хавсралт болох хаалтын төлөвлөгөө нь Уул уурхайн үйл ажилагаа эрхлэгч ба хүсэж өргөдөл гаргагчид зориулсан ус ба агаарын суурь судалгааны мониторингийн удирдамж, баримт бичгийг хангасан байх ба суурь өгөгдөл ба усан орчинд төслөөс үзүүлэх нөлөөлөлийг үнэлсэн байх ёстой. Мэргэшсэн мэргэжилтэн /Qualified Professional/ нь техникийн үнэлгээний тайлан ба БОНБУ-нд гарын үсэг зурж баталгаажуулсан байхыг шаарддаг ба мэргэшсэн мэргэжилтэн болохыг тодорхойлсон тухайн олгосон байгууллага холбооны гишүүнчлэл, гэрчилгээ хавсаргагдсан байна.

Төлөвлөгөөг хянаж батлахад уурхайн хаалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн баталгааг хэдий хэмжээгээр хэрхэн байршуулсан байх нь чухал асуудлын нэг болдог бөгөөд уул уурхайн ахлах байцаагчийн зүгээс зөвшөөрөл/permitee олгоог байна. Энэ Permittee гэдэг уурхайн нийт хугацаанд нөхөн сэргээлтэнд зарцуулагдана гэж үзсэн

хөрөнгийн хэмжээ гэж ойлгогдох ба энэ нь уурхайн ахлах байцаагчийн хүлээн зөвшөөрсөн хэлбэр, хэмжээгээр санхүүгийн баталгааг үүсгэсэн байна. Энэ санхүүгийн баталгаа нь Ерөнхий байцаагч бүх нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа бүрэн биелэгдэнэ гэж үзэх хүртэл үнэт цаас хэлбэрээр байна. Ерөнхий байцаагч нөхөн сэргээлтийн баталгааг бэлэн мөнгө, баталгаажуулсан чек, банкны тооцооны хуудас/банкны баталгаа/, хугацаат хадгаламж, засгийн газрын бонд болон эргэн төлөгдөх нөхцөлтэй өрийн бичиг хэлбэрээр зөвшөөрнө.

Хаалтын төлөвлөгөө, зөвшөөрөл нь бүхэлдээ уул уурхайн ахлах/ерөнхий байцаагч/chief inspector/ хаалтын гэрчилгээнд гарын үсэг зурснаар баталгаажих бөгөөд бусад яам, газраас гэрчилгээнд гарын үсэг шаарддаггүй.

ФИЛИППИН:

Филиппин улс нь Монгол улсын хувьд өрсөлдөгчдийн нэгд зүй ёсоор тооцогддог бөгөөд газар доорхи баялгийн үнэлгээ нь 1.4 триллион амд доллар буюуга тутам нь 9 сая доллар байгаа нь хөрөнгө оруулалтыг ихээр татдаг бөгөөд 1970 –аад онд уул уурхайн оргил /mining boom/ болж байсан бөгөөд 45 том уурхай зэрэг ажиллаж ДНБ-ий 21%-ийг уул уурхайн салбар бүрдүүлж байсан. Харин 1991 онд гарсан бичил уурхайн хууль, баялгийн үндсэрхэг үзэл, иргэний нийгмийн хүчтэй шаардлагуудын дүнд уул уурхай салбар уналтад орсон байна.

Филиппиний уул уурхайн хууль 1995 онд шинэчлэгдэн батлагдсан бөгөөд түүнийг дагасан дүрэм журмуудын хүрээнд зохицуулалт хийгддэг. 2012 онд Хүрээлэн буй орчин, байгалийн баялагийн яамны “Ашигт малтмал ашиглахад хариуцлагатай уул уурхай ба байгаль орчны хамгаалах заавар ба бодлогийг хэрэгжүүлэх үүднээс Филиппиний уул уурхайн салбарт шинэчлэл хэрэгжүүлэх, эзэнжүүлэх тухай” 07 тоот тушаалаар хаалтын талаар хүрээлэн буй орчны менежментийн төлөвлөгөө болон Уурхайн эцсийн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө зааврыг шинэчлэсэн байна.

ХОББЯ-ны харьяа уул уурхай, геошинжлэх ухааны товчоо/mines and geoscience bureau/ (УУГШУТ) уул уурхайн салбарын бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хангуулж, хяналтыг гүйцэтгэх бүрэн эрхтэй байгууллага нь бөгөөд уул уурхайн зөвшөөрөл авснаас 6 сарын дотор Хүрээлэн буй орчны менежментийн төлөвлөгөө болон Уурхайн эцсийн нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө боловсруулан ирүүлхийг шаардах ба 2 жил тутамд шинэчлэн батлуулах үүрэг хүлээнэ.

УУГШУТ нь тухайн компанийг зөвшөөрөл хүссэнээс хойш 6 сарын төлөвлөгөөг хянах бөгөөд хянахдаа талбайн статус, материал бүрдүүлэлтийг 1 сар, уугуул иргэдийн асуудал хариуцсан үндэсний комисс 3-6 сар, орон нутгийн удирдах байгууллагад шуудангаар хүргүүлэж хүргэгдсэнээс 7 хоногийн дотор хариуг ирүүлэх ба хянасан талаар санал зөвлөмжийн 7 хоногт багтаан боловсруулж хүргүүлнэ.

Хэрэв уг уурхай нь нэгэнт үйл ажиллагаа явуулж байгаа бол дахин хэлцэл байгуулах ба хэрэв шинээр уурхай эхлүүлэх хүсэлттэй бол нөөц, ТЭЗҮ зэрэг хуулинд заасан бусад бичиг баримтын хамтаар хэлэлцэнэ.

Үүний дараа Оролцогч талуудын зөвлөл Филиппин улсын үндэсний хөгжлийн төлөвлөгөө, аж үйлдвэржилтийн төлөвлөгөөнд нийцэж буй эсэх талаар уурхайн төлөвлөлтийг хянах бөгөөд энд уугуул иргэдийн асуудал, тусгай хамгаалалттай газар

нутгийн асуудлыг мөн авч үзнэ. Мөн уурхайн бүтээгдэхүүн түүнийг ашиглах, дотоодын үйлдвэрлэлд ашиглах нөхцөл боломжийг авч хэлэлцдэг а бүхэлдээ энэ нь 6 сарын хугацаанд багтана.

Энэ зөвлөлийн дүгнэлтийг авсны эцэст Уул уурхайн яамны дэргэдэх байгаль орчны яам, шинжлэх ухаан технологийн яам, сангийн яам, орон нутаг, эдийн засаг хөгжлийн агентлагийн төлөөлөлийг багтаасан Уул уурхайн үйлдвэрлэлийг зохицуулах зөвлөл /Mining industry coordinating council MICC/ -өөр хэлэлцүүлэн баталдаг. Уг зохицуулах зөвлөлийн шийдвэр нь 6 сарын дотор хуралдаанаар хэлэлцүүлсний үндсэнд шийдвэрлэдэг байна.

Хүнд сурталыг багасгах үүднээс Хүрээлэн буй орчин, байгалийн баялагийн яамны дэргэд нэг цэгийн үйлчилгээ /one-step shop/ ажилладаг бөгөөд аливаа өргөдлийг 6 сарын хугацаанд шийдвэрлэдэг байна.

ДҮГНЭЛТ

Уурхайн хаалтын эрх зүйг боловсруулахдаа цогц байдлаар холбогдох стандарт, шаардлага журмыг хамтад иж бүрэн авч үзэх нь чухал бөгөөд хаалттай холбоотой санхүүжилтийн баталгааг оновчтой хувь хэмжээ, хэлбэрээр байршуулах нөхцөлийг судалж журамлах нь зүйтэй.

Тухайн уурхай байршиж буй орон нутгийн ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог төлөвлөгөө боловсруулах батлах явцыг нээлттэй хэлбэрээр хангаж журамлах, нээлттэй хэлэлцүүлэг, судлаач эрдэмтдийг санал өгөх, оролцох нөхцөлийг боломжийг хангах, төлөвлөлтийг үндэслэлтэй шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн сайн туршлагад үндэслэсэн чанартай байх нөхцөлийг бүрдүүлэх.

Төлөвлөгөөг боловсруулахдаа БОНБУ, эдийн засаг нийгмийн судалгааг сайтар хийсний үндсэн дээр тухайн уурхай болон бүс нутгийн онцлогт тохирсон хэлцэл, шийдлийг тусгаж хийх.

Хаалтын төлөвлөгөөг уурхайн хэмжээ, төрөл, БОНБУ-ээр БО-нд үзүүлэх сөрөг нөлөөлөлөөс шалтгаалан батлах үе шат, тавигдах шаардлагыг ялгаатай зохицуулах боломжтой бөгөөд жижиг уурхайнуудыг орон нутгийн төвшинд шийдвэрлэдэг, харин томоохон уурхайг яам, агентлагийн түвшинд, эсхүл хамтарсан комисс хэлбэрээр хэлэлцэн шийдвэрлэдэг байх нь зүйтэй юм.

Төлөвлөгөөг хүлээн авах процедурыг нарийн журамлаж, нээлттэй байдлыг хангах, хүнд суртал, авилга хээл хахууль үүсэх нөхцөлийг хааж ил тод байдлыг хангасан байх нь чухал юм.

Төлөвлөгөөг хүлээн авахаас татгалзах үндэслэл, хэлэлцүүлгэ хийх, иргэдийн саналыг тусгах, батлах, хянах механизмыг оновчтой тусгах. Ордын хэмжээ ялангуяа уурхайгаас тухайн бүс нутгийн эдийн засаг нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцон уурхай хаасны дараах ажилгүйдэл, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төр болон орон нутгийн байгууллагын оролцоо, бодлогыг тусгах асуудлыг журамлах.

Олон улсад хэрэгжиж буй greenfield санаачлага, NIMBY концепцийн талаар төлөвлөгөөнд тавигдах шаардлагад тусгах нь зүйтэй бөгөөд энэ нь буцаагаад төлөвлөгөөг

хүлээн авахад нээлттэй ил тод байдлыг хангах, хүнд суртал авилгаас зайлсхийхэд тус дөхөм болзо гэж үзэж байна.

Хаалтын төлөвлөгөө хүлээн авах хяналтын хуудасыг уурхайн хаалтын талаарх хууль, журмыг боловсруулахдаа хамтад хавсралт хэлбэрээр хийх нь зүйтэй бөгөөд энд ил тод байдлыг хангаж, хүнд суртал үүсхээс урьдчилан сэргийлсэн байх зүйтэй гэж үзлээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Alex Blood. 2012. Mine closure planning in South Australia and beyond evolving expectation. AusIMM Bulletin October, 2012.

Eduardo Sanzano, Jorgo campos, Andres Lopes. 2016. Implementation of mine closure law in Chile. Learned lessons and opportunity.

Bernadetta Devi ., 2013. Mining and Development in Indonesia: An Overview of the Regulatory Framework and Policies. *International mine development center.p.69.*

Ernesto Sanchez-Triana and Santiago Enriquez. A Comparative Analysis of Environmental Impact Analysis Systems in Latin America. *Annual conference of the international association for impact assessment*

[Dr. A. Robertson , S. Shaw. Infomine e-book. Mine closure](#)

Ana Elizabeth Bastida.,2015. Mine closure planning in Chile. A review of main features of implementation. *Inter-Governmental Forum, Annual General Meeting 2015. Geneva.*

С.Цэдэндорж, Ж.Бямба-Юу, М.Дагва 2010. Уурхайн хаалт эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь. *Нээлттэй нийгэм форум*

АНУ-ын эрх зүйн тогтолцооны товчоон

Ц.Сарантуяа (ScD), Профессор. Үндсэн хуулийн процессын эрх зүй

Campos, Jorge; Lopez, Ricardo; Weeks, Björn; Lypetz, Andrés, “National guide for the estimation of closure costs: The Chilean experience”, Proceedings of Mine Closure Solutions, 2014 April 26–30, 2014, Ouro Preto, Minas Gerais, Brazil Published by InfoMine, 2014 InfoMine, available at <http://www.mineclosuresolutions.com/wp-content/uploads/2014/05/Campos-Jorge-National-guide-for-the-estimation-of-closure-costs-The-Chilean-experience.pdf>

Olivari, Alfonso, “Financial assurance for mine closure in Chile”, Proceedings of Mine Closure Solutions, 2014 April 26–30, 2014, Ouro Preto, Minas Gerais, Brazil, Published by InfoMine, 2014

Trends in the mining and metals industry. ICMM.

Environmental Protection Act 1986. Western Australia. As at 29 Nov 2016 Version 08-f0-00

TEXT OF THE LAW N°19,300 GENERAL BASES OF THE ENVIRONMENT, PUBLISHED ON THE OFFICIAL GAZETTE ON 9th March 1994.Chile.

MINE RECLAMATION AND CLOSURE PLAN UPDATE NOVEMBER 2015 . Western australia.

A Guide to Preparing Revegetation Plans for Clearing Permits under Part V of the *Environmental Protection Act 1986*

Guidelines for Preparing Mine Closure Plans. May 2015 (Revision of the *Guidelines for Preparing Mine Closure Plans*, June 2011).

Guidelines for preparation of mine closure plan. India. Central Gov. Notification No. GSR 329 (E) dated 10.04.2003

IBM manual on appraisal of mining plan 2014. Controller General In-charge Indian Bureau of Mines. Nagpur.

MINES AND MINERALS (DEVELOPMENT AND REGULATION) ACT, 1957 (No. 67 of 1957) (As amended up to 10th May, 2012)

Statutory requirements of mining plan & scheme of mining and mine closure plan. mines & minerals (d&r) act, 1957. India
Mining in Indonesia. Investment and Taxation Guide.

Law on Mineral and Coal Mining No. 4 of 2009 (the "Mining Law") Indonesia.

Dr. Lana Saria., 2015. Implementation of mine closure guarantee on mineral and coal company in Indonesia. *Inter-Governmental Forum, Annual General Meeting 2015. Geneva*.

RoK Law on Subsoil and Subsoil Use dated 24 June 2010 No. 291-IV (the "**Subsoil Law**").

Закон Республики Казахстан. "о недрах и недропользовании" (с изменениями и дополнениями по состоянию на 30.11.2016 г.)

Mine Closure Regulation. THE MINES AND MINERALS ACT (C.C.S.M. c. M162). Canada

Mines (Regulatory) Manitoba Mine closure regulation. 67/99. General closure plan guidelines.

MINES ACT [RSBC 1996] British Columbia.

Ontario regulation 240/00. Mine development and closure under part VII of the Mining act.

Mining Act. R.S.O. 1990, Ontario Mining act.

Amendments to department administrative order no. 96-40, as amended, or the "revised implementing rules and regulations of republic act no. 7942, otherwise known as the 'philippine mining act of 1995.

Pilippine mining act of 1995

Harmonization of the implementation of the Philippine environmental impact statement system and Philipphine Mining act of 1995 in relation to mining project.

Rules and regulations to implement executive order №79 dated 06 July 2012 entitled: Institutionalizing and implementing reforms in Philipphine mining sector providing policies and guidelines to ensure environmental protection and responsible mining in the utilization of mineral resources.

Amendment to section 2 (transitory provision) of DENR administrative order (d.a.o.) no. 2005-07, Amendments to chapter XVIII of DENR administrative order -no. 96-40, as amended, providing for the establishment of a final mine rehabilitation and decommissioning fund.

'Financial Assurance for Mine Closure: A Regulatory Perspective from the Argentine Context

DMP submission. Environment Division. www.dmp.wa.gov.au

www2.gov.bc.ca/gov/content/industry/mineral-exploration-mining/permitting/mines-act-permit-inspection-fees

www2.gov.bc.ca/assets/gov/environment/waste-management/industrial-waste/industrial-waste/mining-smelt-energy/eia__ta_tor.pdf

www2.gov.bc.ca/assets/gov/environment/waste-management/waste-discharge-authorization/assessment.pdf

www2.gov.bc.ca/assets/gov/environment/ /waste-management/industrial-waste/industrial-waste/mining-smelt-energy/mining_operations_fs.pdf

<http://www.mgb.gov.ph/laws-and-regulation>

Servicio de Nacional de Geología y minera (SERNAGEOMIN). [www. Sernageomin.cl](http://www.Sernageomin.cl)